

# ХҮРТЭЭМЖТЭЙ САНХҮҮ

САНХҮҮГИЙН ЗОХИЦУУЛАХ ХОРООНЫ ТОВХИМОЛ

2024 – 08 САР I ДУГААР 69

## ГАРЧИГ



2–5 Бодлогын нийтлэл

6–7 Зохицуулалтын мэдээ

8–9 Байр суурь

10–13 Тогтвортой санхүүжилт

14–15 Компанийн засаглал, комплайнс

16–17 Финтек ба регтек

18–23 Судлаачийн индэр

24–25 Гэнэтийн ослын даатгал

26–27 Олон улсын зах зээлийн мэдээ

28 Олон улсын хөрөнгийн зах зээлийн индекс

## САНХҮҮГИЙН ХЯНАЛТ ШАЛГАЛТ ДАХЬ ТЕХНОЛОГИЙН ХЭРЭГЛЭЭ: ЖИШЭЭ, ЗӨВЛӨМЖ

### СУПТЕКИЙН ОЙЛГОЛТ



### Тодорхойлолт, ач холбогдол

Хяналт, шалгалтын технологи буюу суптек нь санхүүгийн зохицуулалт, хяналт, шалгалтын үйл ажиллагаанд томоохон ахиц дэвшлийг авчирсан. Суптек гэдэг нь хиймэл оюун ухаан, машин сургалт, их өгөгдлийн шинжилгээ, блокчэйн технологи, эх хэлний боловсруулалт зэрэг инновацын технологийг хяналт, шалгалтын үйл ажиллагааг сайжруулахад ашиглахыг хэлэх бөгөөд эдгээр технологийн дэвшил нь санхүүгийн зохицуулагч байгууллагуудыг өөрсдийн хяналт, зохицуулалтын үйл ажиллагаагаа илүү үр дүнтэй, бодит цагийн горимоор боломжийг бүрдүүлж байна.

Уламжлалт санхүүгийн хяналт, шалгалтын үйл ажиллагаа нь гар ажиллагаа ихтэйгээс гадна санхүүгийн өгөгдөл мэдээллийг хугацааны хоцрогдолтой цуглуулан зах зээлийн хөгжил, шинэ тутам үүсэж буй эрсдэлд идэвхгүй хариу үйлдэл үзүүлэх зэрэг олон тооны дутагдалтай бөгөөд суптек нь эдгээр асуудлуудыг үр дүнтэй шийдвэрлэж чаддагаараа ач холбогдолтой юм. Суптекийг үйл ажиллагаандаа нэвтрүүлснээр санхүүгийн зохицуулагч байгууллагууд өдөр тутмын үйл ажиллагаагаа автоматжуулах, тоон мэдээллийн үнэн зөв байдлыг нэмэгдүүлэх, эрсдэлийг таних, илрүүлэх чадамжаа сайжруулах, мөн комплаенсын хяналтыг үр дүнтэй тавих боломжтой юм. Энэхүү технологийн шилжилт нь санхүүгийн зохицуулагч байгууллагуудыг өгөгдөлд суурилсан, технологийн хөгжилд нийцтэй ажиллах нөхцөлийг бүрдүүлж өнөөгийн хурдтай өөрчлөгдөж буй зах зээлийн хөгжлөөс хоцрохгүй байхад тусалж буй юм.

Финтекийн үйлчилгээ, цахим мөнгө, төвлөрсөн бус санхүүгийн зах зээлийн хөгжил нь зохицуулагч байгууллагуудад шинэ сорилтуудыг үүсгэж буй бөгөөд суптекийн шийдлүүд нь санхүүгийн салбар маш хурдтай дижиталчлагдаж буй өнөө цагт улам бүр эрэлт хэрэгцээтэй болж буй. Мэдээж зах зээлийн энэхүү хурдтай өөрчлөлт нь хяналт шалгалтын илүү идэвхтэй, хурдтай, их хэмжээний өгөгдөлтэй ажиллах чадамжтай байхыг шаардаж байна. Суптек нь мэдээж эдгээр асуудлуудын шийдэл бөгөөд санхүүгийн системийг тогтвортой, хүртээмжтэй, аюулгүй байдлаар хөгжих нөхцөлийг бүрдүүлж буй юм.


Үргэлжлэлийг 18-р нүүрт



## ТАНЫ САНХҮҮГИЙН МЭДЛЭГТ

### ХЯНАЛТ

Стандарт тогтоох, бодит гүйцэтгэлийг хэмжих, гаргасан шийдвэр бодит байдалтай нийцэж байгаа эсэхийг тогтоох, аливаа доголдол, түүний шалтгааныг илрүүлэх, залруулах арга хэмжээг хамарсан менежментийн чиг үүрэг.



### CONTROL

A management function which includes setting standards, measuring actual performance, defining the appropriateness of decisions to the actual situation and reasons for deviations and taking corrective action.

*Эх сурвалж: Засаглалын үзэл баримтлал, нэр томъёоны тайлбар толь бичиг*

## БОДЛОГЫН НИЙТЛЭЛ

### ВИРТУАЛ ХӨРӨНГИЙН ҮЙЛЧИЛГЭЭ ҮЗҮҮЛЭГЧИЙН САЛБАРЫН ЗОХИЦУУЛАЛТЫН ӨНӨӨГИЙН НӨХЦӨЛ БАЙДАЛ

#### ОРШИЛ

Хөгжлийн эринд дэлхийд виртуал хөрөнгийн зохицуулалтын анхаарал эрс нэмэгдсэн бөгөөд цаашид ч нэмэгдсээр байх төлөвтэй. Сүүлийн үед виртуал хөрөнгөтэй холбоотой маш олон залилан, луйвар, хэрэглэгчтэй холбоотой буруу менежментийн улмаас энэхүү салбарт итгэх итгэл алдагдаад байна. Энэ нь зохицуулагчдад нэн даруй анхаарал хандуулах цаг нь болсон гэх дохиог өгч байна. Тухайн зах зээлийн шударга байдалд учирч буй эрсдэл нь хэрэглэгчдийн хамгаалалтыг сайжруулахын тулд улс орнууд зохицуулалтын арга барил, хяналтын тогтолцоог түргэн шуурхай, цогцоор нь хэрэгжүүлэх шаардлагатайг харуулсаар байна. Виртуал хөрөнгө болон виртуал хөрөнгийн үйлчилгээ үзүүлэгчтэй холбоотой цогц төлөвлөлт нь байнга хувьсан өөрчлөгдөж хууль эрх зүйн байдал нь нэгээс нөгөөд ихээхэн ялгаатайгаар зохицуулагдаж байна. Зарим нь ашиглах, худалдаалахыг тодорхой зөвшөөрч байхад зарим нь хориглож, хязгаарласан зохицуулалтыг хийж байна.

Санхүүгийн хориг арга хэмжээ авах байгууллага (ФАТФ) нь мөнгө угаах болон терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх дэлхийн стандартуудыг виртуал хөрөнгө болон виртуал хөрөнгийн үйлчилгээ үзүүлэгчид хэрэглэхээр өргөжүүлснээс хойш дөрвөн жил болж байна. ФАТФ-аас виртуал хөрөнгө ба виртуал хөрөнгийн үйлчилгээ үзүүлэгчийн стандартыг баталснаас хойш дөрвөн жилийн дараа хууль эрх зүйн орчин зохицуулалтыг нэвтрүүлсэн боловч дэлхийн хэмжээнд хэрэгжилт харьцангуй муу байна.

Манай улсын хувьд 2021 оны 12 дугаар сарын 17-ны өдөр Виртуал хөрөнгийн үйлчилгээ үзүүлэгчийн тухай хуулийг баталж энэхүү хууль хэрэгжиж эхэлснээр тухайн зах зээл дээрх эрсдэлийг түвшин харьцангуй буурсан гэж үзэж байгаа хэдий ч шинээр гарч ирж байгаа эрсдэл, цаашид үүсэж болзошгүй нөхцөл байдлыг таамаглаж бусад улс орнуудын хэрэгжүүлж буй зохицуулалтыг судалж холбогдох хууль, журамдаа шинэчлэлт хийн хяналтын тогтолцоогоо сайжруулах шаардлага байсаар байна.


Нэлээдгүй олон улс орон виртуал хөрөнгийг одоогийн санхүүгийн үйлчилгээний хүрээнд авчрахын тулд судалгаа хийж, зөвлөгөө авч, хууль тогтоомжоо боловсруулж байна. Гэсэн хэдий ч үйл ажиллагааны хурд, хэрэгжүүлсэн арга барил, үйлчилгээ, бүтээгдэхүүн, тэр ч байтугай ашигласан тодорхойлолт, нэр томъёо нь маш хуваагдмал хэвээр байна.

#### ШИГТГЭЭ

Виртуал хөрөнгүүд нь хяналтаас ангид ажиллахаар анх бий болсон байж болох ч энэ хөрөнгийн талаарх дэлхийн хууль эрх зүйн тогтолцоо байхгүй байгаа нь санхүүгийн салбар, инновац, хэрэглэгчийн эрхийг хамгаалахад ихээхэн хохиролтой.

## ЗАХ ЗЭЭЛИЙН ТАЛААР


Сүүлийн хорин жилийн хугацаанд дэлхийн эдийн засагт нөлөөлсөн сөрөг үйл явдлуудын хариуд (дэлхийн санхүүгийн хямрал, улсын өрийн хямрал, COVID-19 цар тахал) төв банкнууд эдийн засгийг тэлэх хэд хэдэн арга хэмжээг хэрэгжүүлэн дэмжсэн. Хөрвөх чадвар өндөр, хүү багатай энэ нөхцөлд хөрөнгө оруулагчид хөрөнгөө өндөр өгөөжтэй, эрсдэл өндөртэй байдаг хөрөнгийн ангилалд чиглүүлсээр байна. Энэ хөрөнгүүдийн нэг бол виртуал хөрөнгө юм.



Эх сурвалж: [www.coingecko.com](http://www.coingecko.com)

Санхүүгийн таагүй нөхцөл нь виртуал хөрөнгө гэлтгүй бусад бүх хөрөнгийн үйл ажиллагаа эрхлэгчдэд дүн шинжилгээ хийх боломжийг олгодог үе мөн. Дээрх зурагт харуулснаар виртуал хөрөнгийн зах зээлийн үнэлгээ харагдаж байгаа бөгөөд тус хөрөнгийн оршин тогтнох арван дөрвөн жилийн хугацаанд зах зээл тогтвортой өсөж, саяхан Ковид-19 цар тахлын дэгдэлтээс хойш бид энэ сегмент улам өргөжин тэлсний гэрч болсон. 2020 онд виртуал хөрөнгийн нийт зах зээлийн үнэлгээ 200 тэрбум ам.доллар болсон 2021 онд дээд цэгтээ хүрч, хоёр жил хүрэхгүй хугацаанд 1,400 хувиар өсөж, 3 их наяд орчим ам.долларт хүрчээ. 2024 оны 4 дүгээр сард Биткойн halving болж мөн АНУ-ын Үнэт цаас, биржийн хорооноос 2024 оны 01 дүгээр сарын 10-ны өдөр Биткойн спот (ETF), 2024 оны 7 дугаар сарын 22-ны өдөр Этэриум (ETF) зөвшөөрлийг олгож, сертификат олгосон нь олон улсад 2024 онд виртуал хөрөнгийн хэрэглээ нэмэгдэх шалтгаан болж, салбарын зах зээлийн үнэлгээ өмнөх 2 жилтэй харьцуулахад өссөн байдалтай байна.

Виртуал хөрөнгөтэй холбоотой гэмт хэрэг, залилан луйвар нь зохицуулагч байгууллагуудын нэн тэргүүний асуудал байсаар байна.



Эх сурвалж: [www.coingecko.com](http://www.coingecko.com)

2022 онд 31.5 тэрбум ам.долларын виртуал хөрөнгө хууль бусаар шилжүүлэгдсэн нь 2021 оныхоос 72.1 хувиар өссөн үзүүлэлт юм. Харин 2023 онд виртуал хөрөнгө хууль бусаар шилжүүлэгдэх тохиолдол харьцангуй буурч байгаа нь DeFi, блокчейн зэрэг технологийн өсөлттэй холбон тайлбарлаж байна. Виртуал хөрөнгийн үйлчилгээ үзүүлэгчид хууль бус виртуал хөрөнгийн том хүлээн авагч болж байгаа нь хамгийн том асуудал болоод байна. Тухайн нөхцөл байдлыг

биржүүд үйл ажиллагааг хариуцсан албанд мэдээлэх, тухайн хэрэглэгчдийн эсрэг арга хэмжээ авах дүрэм журмыг дагаж мөрдөх арга хэмжээ авдаг. Гэсэн ч эдгээр биржүүд нь хууль бус виртуал хөрөнгийг бэлэн мөнгө болгон хөрвүүлэх боломжтой учраас энэ асуудал болон бусад үйл ажиллагаатай холбоотой эрх зүйн болон зохицуулалтын ямар нэгэн арга хэмжээг олон санхүүгийн байгууллагууд, улс орнууд авсаар байна.


## ОЛОН УЛСЫН ВОРТУАЛ ХӨРӨНГИЙН ЗОХИЦУУЛАЛТ

Дэлхий даяар виртуал хөрөнгийн хэрэглээ нэмэгдсэнээр улс орнууд тэдгээрт тохирох эрх зүйн орчныг бүрдүүлэх чиглэлээр тодорхой арга хэмжээг хэрэгжүүлж эхэлсэн байна. Гэхдээ улс орнууд виртуал хөрөнгийн талаар өөр хоорондоо ялгаатай зохицуулалт хийж байгааг онцлох нь зүйтэй. Аливаа улс орнуудад эрсдэлийг бууруулахын тулд авч хэрэгжүүлэхийг хүсэж буй арга барил нь өөр өөр байна. Зарим улс орнууд виртуал хөрөнгөтэй холбоотой үйл ажиллагааг хориглох шийдвэр гаргасан байхад зарим нь мөнгө угаах терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх зорилгоор үйл ажиллагааг зохицуулахаар сонгосон.

Виртуал хөрөнгийн экосистем үргэлжлэн хөгжиж, илүү олон виртуал хөрөнгийн үйлчилгээ үзүүлэгчид мөнгө угаах, терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх хяналтыг хэрэгжүүлсээр байгаа нь сайшаалтай. Улс орнуудын хөгжлийн түвшнээс

хамаараад авч хэрэгжүүлсэн арга хэмжээ нь харилцан адилгүй байгаа ба хөгжлийн түвшин өсөх тусам хууль эрх зүйн орчинд өөрчлөлт хийх, тусгайлан хууль батлах зэргээр зохицуулах хандлагатай байна. ФАТФ-аас 2023 оны судалгаагаар улс орнууд виртуал хөрөнгийн салбарт ямар арга барил ашиглах талаараа шийдэх шатандаа байна гэж дүгнэсэн. Тус судалгаанд 151 улс хамрагдсан ба судалгаанд оролцогчдын 30 орчим хувь буюу 45 улс энэ салбарыг зохицуулах эсэх, хэрхэн зохицуулахаа хараахан шийдээгүй байна гэж мэдэгджээ. Дийлэнх нь буюу 90 улс виртуал хөрөнгийг ашиглаж, виртуал хөрөнгийн үйлчилгээ үзүүлэгчийг үйл ажиллагаа эрхлэхийг зөвшөөрөх шийдвэр гаргасан. Виртуал хөрөнгийн үйлчилгээ үзүүлэгчийг хориглохыг сонгосон улс орнуудын эзлэх хувь өнгөрсөн онтой харьцуулахад бага зэрэг нэмэгдэж, 2022 онд 7 улс байсан бол 2023 онд 16 болж өссөн байна.

Зураг. Олон улсын ВХҮҮ салбарын зохицуулалтын хэлбэр



Зөвшөөрсөн орнуудын хувьд бүртгэл, лиценз олгож, санхүүгийн үйлчилгээний тухай ямар нэгэн хуулиараа, эсвэл тус хөрөнгөтэй холбоотой харилцааг зохицуулах тусгай хууль баталж хяналтын тогтолцоогоо сайжруулсаар байна. Зөвшөөрсөн улс орнуудын хувьд доорх нийтлэг шаардлагыг тавьж байна:

Виртуал хөрөнгө гаргагч нь олон нийтэд тус хөрөнгийг санал болгохоос өмнө эсвэл арилжааны платформ дээр виртуал хөрөнгийг арилжаалахад дараах үүргийг биелүүлэх ёстой:

- Албан ёсны платформдоо үйл ажиллагаа хэрхэн явагддаг талаар тайлан, "white paper"-г олон нийтэд нээлттэйгээр байршуулах;

- Зах зээлд харилцагчийн итгэлийг хүлээсэн, өөрийн гэсэн бат бөх байр суурийг бий болгосон байх;
- Хуулийн этгээдийн бүртгэл, сүүлийн гурван жилийн санхүүгийн тайлан болон үйл ажиллагаа эрхлэгч хувь хүн, хуулийн этгээдийн дэлгэрэнгүй мэдээлэл;
- Тус виртуал хөрөнгийн товч танилцуулга;
- Цаашдын бизнес төлөвлөгөө гэх мэт.

Виртуал хөрөнгийн үйлчилгээ үзүүлэхээр хүсэлт гаргасан хуулийн этгээд нь доорх шаардлагуудыг хангасан байх ёстой:

- Шударга, хэрэглэгчдийнхээ эрх ашгийн төлөө ажилладаг;
- ТУЗ-н гишүүд болон хувьцаа эзэмшигчид зохих стандартын дагуу хувьцаа эзэмшиж байгаа эсэхийг батлах;
- Хөрөнгийн хадгалалтын бат бөх, найдвартай стандартыг нэвтрүүлэх;
- Гомдлыг шуурхай, шударгаар шийдвэрлэх журмыг хэрэгжүүлэх;
- Ашиг сонирхлын зөрчлийг шуурхай, шударгаар олж тогтоох, урьдчилан сэргийлэх, зохицуулах;
- Эрсдэлд хяналт тавьж, зохицуулагч байгууллагын шаардлагыг дагаж мөрдөх;
- Кибер халдлагын үед хэрэглэгчийн виртуал хөрөнгийг алдах эрсдэлээс урьдчилан сэргийлэх арга хэмжээ авсан байх, гарсан тохиолдолд хариуцлага хүлээх бүрэн чадамжтай байх;
- Арилжааны платформ нь тогтвортой байдлыг хангах үйл ажиллагааны дүрэм журам, техникийн арга хэмжээ тогтоох шаардлагатай гэх мэт.

## МОНГОЛ УЛСЫН ЗОХИЦУУЛАЛТ

Монгол Улсын хувьд Виртуал хөрөнгийн үйлчилгээ үзүүлэгчийн тухай хуулийг 2021 оны 12 дугаар сарын 17-ны өдөр баталж, 2022 оны 02 дугаар сарын 25-ны өдрөөс хүчин төгөлдөр мөрдөгдөж эхэлсэн. Тус хуулийн дагуу Санхүүгийн зохицуулах хороо нь виртуал хөрөнгийн үйлчилгээ үзүүлэгчийн нийт 10 харилцааг зохицуулсан 8 журмыг баталсан. Дээрх хууль, эрх зүй бүрдсэнтэй холбоотойгоор Санхүүгийн зохицуулах хороо нийт 12 хуулийн этгээдийг виртуал хөрөнгийн үйлчилгээ үзүүлэгчээр бүртгэсэн.

Санхүүгийн зохицуулах хороонд 2024 оны 2 дугаар улирлын байдлаар арилжааны самбарт нийт 724 гадаадын виртуал хөрөнгө, дотоодын 45 виртуал хөрөнгө арилжаалагдсан. Дотоодын виртуал хөрөнгийн зах зээлийн үнэлгээ 161.5 тэрбум төгрөг, өдөрт дунджаар 300.8 сая төгрөгийн дотоодын виртуал хөрөнгийн арилжаа явагдсан ба гадаад виртуал хөрөнгийн арилжаа 376.01 тэрбум төгрөгт хүрсэн. Бүртгэлтэй 12 ВХҮҮ дээр давхардсан тоогоор нийт 921,022 харилцагч бүртгэлтэй ба үүний 41.9 хувь буюу баталгаажуулалт хийсэн, 1.6 хувь идэвхтэй арилжаа хийдэг харилцагч байна.

Санхүүгийн зохицуулах хорооноос виртуал хөрөнгийн үйлчилгээ үзүүлж байгаа болон үйл ажиллагаагаа зогсоосон, виртуал хөрөнгийг олон нийтэд санал болгож, худалдах замаар хөрөнгө татан төвлөрүүлсэн этгээдүүдийн үйл ажиллагаа, хөрөнгийн зарцуулалтад төрийн хянан шалгах чиг үүрэг

бүхий холбогдох байгууллагуудтай хамтран хяналт, шалгалт хийх зорилгоор Санхүүгийн зохицуулах хорооны даргын 2023 оны 59 дүгээр тушаалаар төрийн байгууллагуудын хамтарсан ажлын хэсэг байгуулагдсан. Тус ажлын хэсгийн хүрээнд Улсын бүртгэлийн ерөнхий газар, Гаалийн ерөнхий газар, Татварын ерөнхий газар, Монголбанк, Харилцаа холбооны зохицуулах хороо, Монголын биржүүдийн нэгдсэн холбоо, Санхүүгийн зохицуулах хороонд бүртгэлтэй виртуал хөрөнгийн үйлчилгээ үзүүлэгч гэх зэрэг төрийн болон хувийн байгууллагуудаас бүргэлтэй, бүртгэлгүй виртуал хөрөнгө болон виртуал хөрөнгийн үйлчилгээ үзүүлэгчийн холбогдох мэдээ, мэдээллийг авч, дүн шинжилгээ хийж, эрсдэлийн үнэлгээ, тайлан дүгнэлт боловсруулсан.

Санхүүгийн зохицуулах хороо “Монголын биржүүдийн нэгдсэн холбоо” ГҮТББ-тай хамтран Санхүүгийн зохицуулах хороонд бүртгэлтэй виртуал хөрөнгийн үйлчилгээ үзүүлэгчийн технологийн дэд бүтцийн тасралтгүй, найдвартай ажиллагаа, нууцлал, аюулгүй байдал, дотоод хяналт, МУТСТ шаардлагыг хангасан эсэхэд дүгнэлт гаргалаа.

Санхүүгийн зохицуулах хороо API системээр дамжуулан виртуал хөрөнгийн үйлчилгээ үзүүлэгчдээс арилжааны дэлгэрэнгүй мэдээлэл, хэрэглэгчдийн тоо, ханшийн мэдээлэл зэргийг өдөр бүр бодит цагийн горимоор хүлээн авч зайнаас хяналт, шалгалтыг хэрэгжүүлэн ажиллаж байна.

## ЗОХИЦУУЛАЛТЫН МЭДЭЭ

### УИХ-ЫН ЭДИЙН ЗАСГИЙН БАЙНГЫН ХОРООНЫ ГИШҮҮД САНХҮҮГИЙН ЗОХИЦУУЛАХ ХОРООНЫ ҮЙЛ АЖИЛЛАГААТАЙ ТАНИЛЦЛАА



УИХ-ын Эдийн засгийн байнгын хорооны гишүүд Санхүүгийн зохицуулах хорооны үйл ажиллагаатай өнөөдөр танилцлаа. Санхүүгийн зохицуулах хорооны дарга Д.Баярсайхан энэ үеэр хорооны үйл ажиллагаа, санхүүгийн зах зээлийн өнөөгийн нөхцөл байдал, санхүүгийн салбарт хэрэгжүүлж буй бодлого зохицуулалт, онцлох ажлуудынхаа талаар товч танилцуулсан юм.

Тодруулбал, сүүлийн жилүүдэд санхүүгийн салбарын холбогдох хуулиудад орсон нэмэлт өөрчлөлт, шинээр батлагдсан хууль, эрх зүйн орчинтой холбоотойгоор хорооны чиг үүрэг нэмэгдсэний зэрэгцээ зохицуулалттай салбарын үнэлгээ ДНБ-ийн нэлээдгүй хувьтай тэнцэх хэмжээнд өргөжин хөгжиж буйг онцлон дурдаад зохицуулалтын байгууллагуудын тоо тэр дундаа Монгол Улсын хөрөнгийн



зах зээл сүүлийн жилүүдэд тогтмол өндөр өсөлт үзүүлж буй талаар онцолсон юм. Тухайлбал системийн нөлөө бүхий банкнууд, төрийн өмчит компаниудын хувьчлал амжилттай хэрэгжиж хөрөнгийн зах зээлийн үнэлгээ 5.9 их наяд төгрөгт хүрэн, 2.2 дахин нэмэгдээд байгаа мөн хөрөнгийн зах зээлийг олон улсын түвшинд гаргах, Ази, Номхон далайн орнуудын хөрөнгийн зах зээлтэй холбох, дотоодын аж ахуйн нэгж компаниудыг гадаадын хөрөнгийн биржид давхар бүртгүүлэх, хадгаламжийн бичиг гаргах, гадаадын хөрөнгө оруулагчийг татах зорилгоор “Mongolia’s Capital Market Connectivity: Hong Kong”, “Shanghai” цуврал арга хэмжээг зохион байгуулах зэргээр гадаадын хөрөнгө оруулагчдыг татахад анхааран ажиллаж байгаагаа танилцуулсан юм. Түүнчлэн ногоон санхүүгийн салбар болон цахим технологид суурилсан санхүүгийн зах зээлийг хөгжүүлэх чиглэлд анхаарч ажиллаж энэ хүрээнд нэр бүхий улс орнуудын зохицуулагч байгууллагуудаас сайн туршлагаас суралцахаар хандаад буйг онцоллоо.



Энэ үеэр УИХ-ын Эдийн засгийн байнгын хорооны дарга Р.Сэддорж болон гишүүдээс холбогдох асуудлуудын талаар хариулт авсны зэрэгцээ Монгол Улсын санхүүгийн салбар сүүлийн жилүүдэд өндөр өсөлтийг үзүүлэхэд СЗХ-ноос оруулж буй хувь нэмрийг онцлон дурдаад цаашид тулгамдсан асуудал, бэрхшээлийг шийдвэрлэхэд анхаарч хамтарч ажиллахаа илэрхийллээ.

### “СЭНДЛИ 2.0” БОНДЫН АНХДАГЧ ЗАХ ЗЭЭЛИЙН АРИЛЖАА ЭХЭЛЛЭЭ

“Сэндли ББСБ” ХК-ийн олон нийтэд санал болгон хоёр дахь удаагаа гаргаж буй бондын арилжааг эхлүүлэх цан цохих ёслол боллоо. Санхүүгийн салбарын бэлгэдэл болсон санхүүчдийн

талбай буюу бухын хөшөөний урд болсон энэхүү ёслолын арга хэмжээнд Санхүүгийн зохицуулах хорооны дэд дарга Т.Цэрэнбадрал, “Монголын хөрөнгийн бирж” ХК-ийн Бизнес хөгжлийн газрын захирал Т.Хаш-Эрдэнэ, “Сэндли ББСБ” ХК-ийн ТУЗ-ийн дарга Б.Наранбат, “Өлзий&Ко капитал ҮЦК”-ийн гүйцэтгэх захирал Б.Өлзийбаяр болон холбогдох бусад хүмүүс оролцсон юм.

Санхүүгийн зохицуулах хорооны дэд дарга Т.Цэрэнбадрал арга хэмжээг нээж хэлсэн үгэндээ “Санхүүгийн зохицуулах хороо олон тулгуурт санхүүгийн зах зээл тэр дундаа хөрөнгийн зах зээлийг хөгжүүлэх хүрээнд бодлого зохицуулалтын хэд хэдэн цогц арга хэмжээг хэрэгжүүлж ажиллаж байна. Үүний үр дүнд сүүлийн жилүүдэд нэлээдгүй ахиц дэвшил гарсан бөгөөд хөрөнгийн зах зээлийн үнэлгээ энэ оны эхний хагас жилийн байдлаар 11.3 их наяд төгрөгт хүрсэн нь өмнөх оны мөн үетэй харьцуулахад 2.8 хувиар өсөж ДНБ-ний 16.4 хувьтай тэнцээд байна. Мөн компанийн өрийн хэрэгслийн анхдагч зах зээлийн арилжаагаар 520 тэрбум төгрөг, хоёрдогч зах зээлийн арилжаагаар 45 тэрбум төгрөгийн арилжаа явагдсан нь өмнөх оны мөн үетэй харьцуулахад 15.1 дахин өссөн үзүүлэлт юм. Сүүлийн дөрвөн жилийн байдлаар гэхэд аж ахуйн нэгж байгууллагуудаас нийт 18 нээлттэй бонд гаргаж ойролцоогоор 1,4 их наяд төгрөгийг татан төвлөрүүлээд байна. Тухайлбал, манай улсын хөрөнгийн зах зээлийн хувьд түүхэндээ анх удаа орон нутгийн бонд буюу Улаанбаатар хотын бонд гарсныг та бүхэн мэдэх байх. Хөрөнгийн зах зээл ийнхүү идэвхжиж, улс орны эдийн засагт гүйцэтгэх үүрэг өдрөөс өдөрт өсөж байгаа нь энэ зах зээлд оролцогч мэргэжлийн байгууллагууд, хөрөнгө оруулагчид, үнэт цаас гаргагчид, төр, хувийн хэвшлийн хамтын ажиллагааны үр дүн гэдгийг онцлох нь зүйтэй болов уу. Ингээд санхүүгийн үйлчилгээг харилцагчдадаа хялбар шуурхай болгож, санхүүгийн хүртээмжийг нэмэгдүүлэхэд хувь нэмрээ оруулж буй “Сэндли ББСБ” ХК-ийн нийтэд санал болгон гаргаж буй өрийн хэрэгслийн анхдагч зах зээлийн арилжаанд нь амжилт хүсье” гэсэн юм.

Анхдагч зах зээлийн арилжаагаа нээж буй тус компанийн энэ удаагийн бонд нь 24 сарын хугацаатай, 18.5 хувийн хүүтэй, 100,000 төгрөгийн нэрлэсэн үнэтэй ба нийт 10 тэрбум төгрөгийг татан төвлөрүүлэх юм байна.



## ДЭЛХИЙН ХАДГАЛАМЖ, ЗЭЭЛИЙН ХОРШООДЫН ЗОХИЦУУЛАГЧДЫН ЗӨВЛӨЛИЙН ХУРАЛ БОЛЛОО

Дэлхийн хадгаламж, зээлийн хоршоодын зохицуулагчдын зөвлөл (ICURN)-ийн хурал Африк тивийн Кени улсад энэ сарын 17-19-ний өдрүүдэд болж дэлхийн 16 орны зохицуулалтын байгууллагын 49 төлөөлөгч оролцлоо. Африк тивийн зохицуулалтын байгууллагын нэгдсэн форум энэ үед давхар болсноороо онцлог байлаа. Хуралд оролцогч зохицуулалтын байгууллагуудын төлөөллүүд хадгаламж, зээлийн хоршооны салбарын өнөөгийн байдлыг танилцуулж, хиймэл оюун ухаан, дижитал технологи, олон нийтийн сүлжээний мэдээллийн хяналт, үйл ажиллагааны автоматжуулалт, кибер аюулгүй байдлын алдаанууд, хадгаламж хамгааллын системийн шинэчлэл, уур амьсгалын өөрчлөлтөд дасан зохицоход авч хэрэгжүүлж буй зохицуулалтын арга хэмжээ, нано зээл, финтек үйлчилгээний санхүүжилтийн төрлийг тодорхойлж үнэлэх болон зах зээлийн хурдацтай шинэчлэлт зэрэг тулгамдаж буй асуудлуудыг хөндөж, өөрийн орны туршлага, шийдлийн талаар ярилцлаа.

Уур амьсгалын өөрчлөлтөд дасан зохицоход зохицуулалтын байгууллагууд хэрхэн ажиллаж байгаа талаар АНУ-ын Мэрилэнд муж болон Сейшэлын арлын хадгаламж, зээлийн хоршооны зохицуулагч нартай туршлага хуваалцах хэлэлцүүлэгт Санхүүгийн зохицуулах хорооны төлөөлөл мөн модератороор оролцсон юм.

## БАЙР СУУРЬ

### КОМПАНИЙН ЗАСАГЛАЛ БА КОМПЛАЙНС – ЭРСДЭЛИЙН УДИРДЛАГЫН ТОГТОЛЦООНЫ НЭГ НЭГНЭЭ НӨХӨЖ БАЙДАГ ХАРИЛЦАН ХАМААРАЛ БҮХИЙ БҮРЭЛДЭХҮҮН ХЭСГҮҮД

*Компанийн засаглал, комплайнсын хэлтсийн дарга А.Авиртай ярилцлаа.*



**Танд энэ өдрийн мэнд хүргэе. Сүүлийн үед анхаарлын төвд ороод байгаа компанийн засаглал болон комплайнс, тэдгээрийн үндсэн зорилго, хамрах хүрээний талаар ярилцлагаа эхэлье.**

Өдрийн мэнд хүргэе. Компанийн засаглал гэдэг нь байгууллагыг удирдан чиглүүлэх, хянах үйл явцын цогц тогтолцоо гэж хэлэхээр. Үүнд хувьцаа эзэмшигч, төлөөлөн удирдах зөвлөл (цаашид “ТУЗ” гэх), гүйцэтгэх удирдлага, ажилтан, үйлчлүүлэгч, олон нийт зэрэг компанийн үйл ажиллагаанд оролцогч талууд хоорондын харилцаа хамардаг. Үндсэн зорилго нь компанийн үйл ажиллагаа болон шийдвэр гаргах үйл явц ил тод, шударга, ёс зүйтэй байхыг хангахад оршино.

Компанийн үр дүнтэй засаглал нь оролцогч талуудын эрх ашгийг хамгаалахын зэрэгцээ компанийг тогтвортой өсөлтөд чиглүүлэх тогтолцоог бий болгоход тусалдаг.

Харин комплайнс нь компани үйл ажиллагаандаа хууль тогтоомж, дүрэм журам, бодлого, стандартыг дагаж мөрдөх явдал. Өөрөөр хэлбэл, байгууллагын бүхий л үйл ажиллагаа хууль эрх зүй, ёс зүйн хүрээнд явагдаж, зохицуулагч байгууллагаас тогтоосон шаардлагыг хангаж байгаа эсэхийг баталгаажуулах үйл явц гэж ойлгох боломжтой.

Ерөнхийд нь компанийн засаглал гэж байгууллагын үйл ажиллагааг зохион байгуулж, хэрэгжүүлэх үндсэн хүрээг бүрдүүлж, хууль тогтоомж, дүрэм журам, бодлогын хэрэгжилтийг хангахад голлох оролцогч талууд, тэр дундаа ТУЗ, гүйцэтгэх удирдлагын үүрэг, хариуцлагыг нарийвчлан тодорхойлдог бол комплайнс нь эдгээр эрх зүйн зохицуулалтууд болон бизнесийн ёс зүйн хэм хэмжээнд үйл ажиллагаагаа нийцүүлж буйг баталгаажуулахад чиглэгддэг. Ингэхээр эдгээр нь хамтдаа бизнесийнхээ үйл ажиллагаа болон үүрэг хариуцлагаа нийтэд мэдээлэх, бусад оролцогч талуудын сонирхлыг татсанаар байгууллагынхаа нэр хүндийг өсгөх, ирээдүйн амжилт, тогтвортой байдалд хувь нэмэр оруулдаг харилцан хамаарал бүхий нэг нэгнээ нөхөж байдаг бүрэлдэхүүн хэсгүүд юм.

#### **Компанийн засаглалын кодексийн шинэчлэл болон хэрэгжилтийн явцын талаар мэдээлэл өгвөл?**

Монгол Улсын Их Хурлын 2006 оны 45 дугаар тогтоолын хавсралтаар батлагдсан “Санхүүгийн зохицуулах хорооны дүрэм”-д зааснаар хуульд заасан бүрэн эрхийнхээ хүрээнд олон улсад хүлээн зөвшөөрөгдсөн компанийн засаглалын зарчмыг нэвтрүүлэх, боловсронгуй болгох үндсэн зорилтыг ханган биелүүлэх үүргийг Санхүүгийн зохицуулах хороо (цаашид “СЗХ” гэх) хүлээдэг.

Үүний хүрээнд СЗХ-ноос “Монголын компанийн засаглалын кодекс”-ийг 2007 онд баталж, хувьцаа нь нийтэд чөлөөтэй арилжаалагддаг компанид мөрдөж ажиллахыг зөвлөсөн бол 2014 онд нэмэлт өөрчлөлт оруулан Монголын хөрөнгийн биржийн “А” самбарт бүртгэлтэй компаниудад үүрэг болгосон байдаг.

Гадна талд 2015 онд Их 20/Эдийн засгийн хамтын ажиллагаа, хөгжлийн байгууллагаас “Компанийн засаглалын тулгуур зарчмууд”-ыг сайжруулан баталсан бол Олон улсын компанийн засаглалын холбооноос анх 2001 онд баталсан “Дэлхийн засаглалын зарчмууд”-аа 2017 онд шинэчилж, 2021 онд томоохон хэмжээний засварууд орсон. Мөн Европын сэргээн

босголтын банкны 2017 оны “Шилжилтийн эдийн засаг дахь компанийн засаглал: Монгол Улс” хэмээх тайланд манай орны компанийн засаглалын кодекс нь зарим талаараа учир дутагдалтай гэж дүгнэгдсэн байдаг.

Эдгээр нөхцөл байдал, манай орны кодексийн хэрэгжилт хангалтгүй байсан зэрэг нь түүнийг сайжруулах хэрэгцээ шаардлага үүссэн тул СЗХ-ны 2022 оны 145 дугаар тогтоолын хавсралтаар “Компанийн засаглалын кодекс” шинэчлэн батлагдсан. Энэхүү тогтоолоор нээлттэй хувьцаат компани, даатгалын компани, итгэлцлийн үйлчилгээ эрхлэгч банк бус санхүүгийн байгууллага болон хөрөнгө оруулалтын менежментийн үйл ажиллагаа эрхэлдэг компаниудад кодексийг дагаж мөрдөхийг тус тус үүрэг болгож, хэрэгжилтийг олон улсад түгээмэл ашиглагддаг “Хэрэгжүүл, эсвэл тайлбарла” гэсэн зарчмаар хангуулахаар заасан. Өөрөөр хэлбэл, компани засаглалын зарчмуудын хэрэгжилтийг тайлагнахдаа кодекст дурдсан нийт 36 зүйлийг биелүүлсэн, хэрэв биелүүлээгүй бол биелүүлээгүй шалтгаан, бүтэц, зохион байгуулалтын ямар арга хэмжээ авсныг кодексийн хавсралт болох тайлангийн маягтын дагуу нарийвчлан тайлбарлах үүргийг тусгасан. Түүнчлэн, хууль, журмаар нэгэнт зохицуулсан асуудлыг тусгахгүйгээр, бусад орны кодексийн бүтэц, агуулгын нийтлэг загварыг ашиглаж, компанийн ТУЗ-ийг кодексийн хэрэгжилтийг хариуцах, хяналт тавихаар үүрэгжүүлж, ТУЗ-ийн хараат бус гишүүний чиг үүргээ хэрэгжүүлэх нөхцөлийг бүрдүүлэх, шүгэл үлээх, комплайнсын тогтолцоо зэрэг шинэчлэлүүдийг тусгаж өгсөн нь өмнөх хувилбараас онцлог болсон.

Кодексийн хэрэгжилтийн хувьд СЗХ-ны даргын 2022 оны 336 дугаар тушаалын хавсралтаар “Компанийн засаглалын кодексийн хэрэгжилтийг зохион байгуулах удирдамж”-ыг баталж, эхний ээлжинд зохицуулалттай этгээдийн кодексийн анхдагч болон давтан үнэлгээг хийж эхэлсэн бол 2023 онд зохицуулалттай этгээд болон нээлттэй хувьцаат компаниудын зэрэглэлийг тогтоох ажлыг хэрэгжүүлсэн. Зохицуулалттай этгээдийн хувьд 2022 оны 05 дугаар сард кодексийн хэрэгжилтийн анхдагч үнэлгээ 58.5 хувь байсан бол компани тус бүрд заавар зөвлөмж болон хугацаатай үүрэг даалгавар өгсний дагуу 2023 оны 1 дүгээр улиралд хэрэгжилтийг үнэлэхэд кодексийн хэрэгжилтийн үнэлгээ 69.2 хувь, мөн оны 2 дугаар улиралд 73.4 хувь, 4 дүгээр улиралд 84.9 хувь болж ахиц дэвшлүүд гараад байна. Харин нээлттэй хувьцаат компанийн хувьд 2023 оны 1 дүгээр улиралд анхдагч үнэлгээ 49.8 хувь байсан бол 2 дугаар улиралд кодексийн хэрэгжилтийн үнэлгээ 58.0 хувь, 3 дугаар улиралд 62.4 хувь, 4 дүгээр улиралд 65 хувийн ахиц дэвшлийг үзүүлээд байна.

Кодексийн хэрэгжилтийн тайланг СЗХ-ны цахим хуудаст олон нийтэд нээлттэй байршуулсан тул дэлгэрэнгүй танилцах

боломжтой.

### **Комплайнсын чиглэлээр хэрэгжүүлж буй ажлын талаар мэдээлэл өгвөл?**

Зохицуулагч байгууллагын хувьд СЗХ санхүүгийн зах зээлд оролцогчид, мэргэжлийн холбоод, сургалтын байгууллага, төрийн бус байгууллага болон салбарын мэргэжилтнүүдтэй маш нээлттэй хамтран ажилладаг. СЗХ, Санхүү эдийн засгийн их сургуультай хамтран санхүүгийн байгууллагуудын комплайнсын зохицуулалтын орчныг боловсронгуй болгох зорилгоор олон улсын санхүүгийн салбар дахь комплайнсын эрх зүйн зохицуулалт, хөгжлийн чиг хандлага болон СЗХ-ны зохицуулалттай этгээдийн комплайнсын тогтолцооны өнөөгийн байдлын талаарх судалгааг хийж, “Комплайнсын эрсдэлийг үнэлэх аргачлал”-ыг боловсруулан, оролцогч талуудаас санал авахаар СЗХ-ны цахим хуудаст байршуулсан байна.

Түүнчлэн “Комплайнсын эрсдэлийн үнэлгээ” сэдэвт нээлттэй хэлэлцүүлгийг зохицуулалттай этгээд, мэргэжлийн холбоод, судлаачдын 150 гаруй төлөөллийг оролцуулан амжилттай зохион байгуулж, энэ үеэр эрсдэлийн үнэлгээний аргачлалыг зах зээлд оролцогчдод танилцуулж, ирүүлсэн саналуудыг нэмж тусган СЗХ-ны даргын 2024 оны 52 дугаар тушаалын хавсралтаар “Комплайнсын эрсдэлийг үнэлэх аргачлал”-ыг баталж, уг аргачлалыг таниулах, мөрдүүлэх зорилгоор зохицуулалттай этгээдийн эрх бүхий албан тушаалтнуудад сургалтуудыг зохион байгуулсан.

### **Байгууллага комплайнсын эрсдэлээ үнэлэх ач холбогдол нь юунд байна вэ?**

Өмнө дурдсанчлан комплайнс нь байгууллагынхаа үйл ажиллагааг хууль эрх зүйн орчин болон бизнесийн ёс зүйн хэм хэмжээнд нийцүүлж буйг баталгаажуулахад чиглэгддэг учраас компани өөрийн комплайнсын эрсдэлээ тодорхойлох, урьдчилан сэргийлэх, бууруулах ач холбогдолтой.

### **Цаашид авч хэрэгжүүлэх ажлын талаар?**

СЗХ-ны зүгээс тулгарч буй асуудал, бэрхшээлийг шийдвэрлэх үр дүнтэй, шийдэл, гарц бүхий хэлэлцүүлгийг жил бүр зохион байгуулж, компанийн засаглалын зохицуулалтын орчин, ялангуяа кодекс болон эрсдэлийн үнэлгээний аргачлалыг манай орны практик туршлага, бусад орны сайн жишигт нийцүүлэн тухай бүр цаг алдалгүй боловсронгуй болгох ажлын төлөвлөгөөний дагуу зах зээлд оролцогчид, мэргэжлийн судлаачидтай идэвхтэй хамтран ажиллаж байгааг дурдах нь зүйтэй.

**Ярилцсанд баярлалаа. Танд амжилт хүсье.**  
Баярлалаа.

# ТОГТВОРТОЙ САНХҮҮЖИЛТ

## ТӨСӨЛ БЭЛДЭХЭД ЗОРИУЛСАН ТЕХНИКИЙН ТУСЛАЛЦААНЫ ХӨТӨЛБӨРҮҮД

*ТоС Холбооны Монголын ногоон санхүүжилтийн эх үүсвэрийн судалгааны хэсгээс*

### 1. Дасан зохицох сан (AF)–гийн техникийн туслалцааны хөтөлбөр

Дасан зохицох сангийн итгэмжлэгдсэн байгууллагууд нь уур амьсгалын өөрчлөлтийн нөлөөнд өртөмтгий бүлгүүдэд зориулсан дасан зохицох тодорхой төсөл, хөтөлбөрүүдийг боловсруулж, хэрэгжүүлж, үр дүнтэй удирддаг. Үүнтэй холбоотойгоор Дасан зохицох сан нь 2014 онд Уур амьсгалын санхүүжилтийн бэлэн байдлын хөтөлбөрийг эхлүүлсэн бөгөөд итгэмжлэгдсэн үндэсний хэрэгжүүлэгч байгууллагуудын байгаль орчин, нийгмийн эрсдэл мөн жендэртэй холбоотой асуудлыг тодорхойлох, үнэлэх, бууруулах, удирдах чадавхыг бэхжүүлэхэд чиглэсэн болно.

### 2. Байгаль орчин, нийгмийн бодлого болон жендерийн бодлогод зориулсан техникийн туслалцааны буцалтгүй тусламж

Энэхүү буцалтгүй тусламжийг өмнө нь авч байгаагүй л бол бүх Үндэсний хэмжээний хэрэгжүүлэгч байгууллагууд авах боломжтой.

*Санхүүжилтийн хэмжээ:* Дасан зохицох төсөл, хөтөлбөрүүдийн хүрээнд байгаль орчин, нийгэм, жендэртэй холбоотой эрсдэлийг нэгэн зэрэг удирдах дотоодын чадавхыг бий болгох зорилгоор Үндэсний хэрэгжүүлэгч байгууллага бүрд 25,000 ам.доллар хүртэл санхүүжилт олгоно. ҮХБ (Үндэсний хэрэгжүүлэгч байгууллага) нь уг санхүүжилтийг Дасан зохицох сангийн Байгаль орчин, нийгмийн бодлого болон Жендерийн бодлоготой уялдуулан өөрсдийн төсөл хөтөлбөрийн байгаль орчин, нийгэм, жендерийн асуудлыг тодорхойлох, эрсдэлийг бууруулах, удирдах чадвараа бэхжүүлэх зорилгоор гаднын мэргэжилтэн, зөвлөх авахад ашиглаж болно.

*Өргөдөл хүлээн авах хугацаа:* Жил бүрийн 2 дугаар сарын 1–нээс 3 дугаар сарын 31 болон 7 дугаар сарын 1–нээс 7 дугаар сарын 31–ний хугацаанд өргөдөл хүлээн авдаг.

Уг техникийн туслалцааны хүрээнд үндэсний хэрэгжүүлэгч байгууллага нь дараах үйл ажиллагааг дэмжих хүрээнд зөвлөх үйлчилгээ авах боломжтой. Үүнд:

- Төсөлд байгаль орчин, нийгмийн эрсдэл, жендэртэй холбоотой эрсдэлийг шалгах журам, гарын авлага, удирдамж боловсруулах
- Төслийн байгаль орчин, нийгмийн эрсдэлийн үнэлгээ, жендерийн үнэлгээ хийх, жендерийн мэдрэмжтэй эрсдэлийн удирдлагын төлөвлөгөө боловсруулах журам боловсруулах.
- Олон нийтэд зориулсан мэдээлэл, зөвлөгөөг жендерийн мэдрэмжтэй байдлаар түгээх бодлого, арга замыг боловсруулах
- Төсөл/хөтөлбөрийг хэрэгжүүлэх явцад байгаль орчин, нийгмийн хохирол, жендерийн тэгш бус байдал, жендерийн бусад сөрөг нөлөөлөлтэй холбоотой гомдлыг хүлээн авч шийдвэрлэх ил тод, хүртээмжтэй, шударга, үр дүнтэй механизмыг хөгжүүлэх
- Дасан зохицох сангийн Байгаль орчин, нийгмийн бодлого, жендерийн бодлогыг хэрэгжүүлэхтэй холбоотой сонгогдсон ажилтнуудыг сургах

### 3. Жендерийн бодлогод зориулсан техникийн туслалцааны буцалтгүй тусламж

Жендерийн бодлогын техникийн туслалцааны буцалтгүй тусламжийг дээр дурдсан байгаль орчин, нийгэм болон жендерийн бодлогод зориулсан техникийн туслалцааны буцалтгүй тусламжид хамрагдаагүй бөгөөд жендерийн сөрөг нөлөөллөөс зайлсхийх, багасгах болон/эсвэл сааруулах арга хэмжээ авах замаар жендерийн асуудлыг шийдвэрлэх шаардлагатай ҮХБ–д олгох боломжтой.

*Санхүүжилтийн хэмжээ:* ҮХБ тус бүрд 10,000 ам.доллар хүртэл санхүүжилт олгох ба Дасан зохицох сангийн Жендэрийн бодлогод нийцүүлэн төсөл, хөтөлбөрүүд болон байгууллагын түвшинд жендэртэй холбоотой асуудлыг шийдвэрлэхэд ҮХБ-ын чадавхыг бэхжүүлэхэд зориулан гаднын экспертийг авахад ашиглаж болно

*Өргөдөл хүлээн авах хугацаа:* Жил бүрийн 2-р сарын 1-нээс 3-р сарын 31 болон 7-р сарын 1-наас 7-р сарын 31-ний хугацаанд өргөдөл хүлээн авдаг.

Буцалгүй тусламж нь дараах үйл ажиллагааг дэмжих зорилготой. Үүнд:

Дасан зохицох сангийн жендэрийн бодлоготой уялдуулан жендэрийн сөрөг нөлөөллөөс зайлсхийх, багасгах, бууруулах арга хэмжээнүүдийг авч, байгаль орчин, нийгмийн эрсдэлийг шалгах төслүүдийг одоо байгаа журам/гарын авлага/ удирдамжийг шинэчлэх;

Эмэгтэй, эрэгтэй хүмүүсийн өөр өөр хэрэгцээ, чадвар, үүрэг, мэдлэгийн нөөцийг тодорхойлох, жендэрийн динамик өөрчлөгдөх нь урт хугацааны өөрчлөлтийг хэрхэн хөдөлгөж болохыг тодорхойлох зорилгоор жендэрийн үнэлгээ хийх журмыг боловсруулах. Уг журмыг төслийн байгаль орчин, нийгэм эдийн засгийн үнэлгээ хийх журамтай нэгтгэж болно;

Олон нийтэд зориулсан мэдээлэл, зөвлөгөөг жендэрийн мэдрэмжтэй байдлаар түгээх бодлого, арга замыг боловсруулах;

Төсөл/хөтөлбөрийг хэрэгжүүлэх явцад байгаль орчин, нийгмийн хохирол, жендэрийн тэгш бус байдал, жендэрийн бусад сөрөг нөлөөлөлтэй холбоотой гомдлыг хүлээн авч шийдвэрлэх ил тод, хүртээмжтэй, шударга, үр дүнтэй механизмыг хөгжүүлэх;

АФ сангийн Жендэрийн бодлогыг хэрэгжүүлэхтэй холбоотой сонгогдсон ажилтнуудыг сургах

#### 4. Агро бизнесийн хөрөнгийн сан (АВС) техникийн туслалцаа

АВС сан өөрийн Техникийн туслалцааны сангаараа дамжуулан хөрөнгө оруулалт авсан байгууллагуудын чадавхыг нэмэгдүүлж, бизнесээ хөгжүүлэхэд нь дэмжлэг үзүүлдэг. Тус сан нь бизнесээ хөгжүүлэх, үйл ажиллагаагаа нэмэгдүүлэх, маркетинг, засаглал, санхүүгийн удирдлага болон чадавхжуулах шаардлагатай бусад чиглэлээр техникийн болон зөвлөх үйлчилгээг санал болгодог. Гол зорилго нь хөрөнгө оруулсан байгууллагуудын бизнесийг бэхжүүлэх,

байгаль орчин, нийгмийн эрсдэл болон бусад эрсдэлийг бууруулахад чиглэнэ.

Техникийн туслалцааны санг Agriterra ([www.agriterra.org](http://www.agriterra.org)) байгууллага Advance consulting болон Rabo partnership байгууллагуудтай хамтран удирддаг ба ЖДҮ, санхүүгийн байгууллагууд, хоршоод болон фермерийн байгууллагуудыг чадавхжуулах үйлчилгээ үзүүлнэ. ТТСан нь зөвхөн АВС сангаас санхүүжилт авч буй байгууллагуудад хамаарна.

#### 5. Канадын худалдаа, хөрөнгө оруулалтын хөгжлийн сан (СТИФ)

СТИФ нь Канадын Global Affairs байгууллагаас санхүүжүүлдэг Ази номхон далайн улс орнуудад илүү хүртээмжтэй, тогтвортой, ядуурлыг бууруулах худалдаа, хөрөнгө оруулалтыг дэмжих зорилгоор техникийн туслалцаа үзүүлдэг байгууллага юм. Мөн СТИФ нь Ази номхон далайн бүс нутгийн хөгжиж буй орнуудын тогтвортой хүртээмжтэй өсөлт, эмэгтэйчүүдийн эдийн засгийн чадавх бэхжүүлэхэд чиглэсэн худалдаа, хөрөнгө оруулалтын бодлогыг бий болгоход дэмжлэг үзүүлдэг ба тухайн улсын засгийн газар болон байгууллагуудын хэрэгцээнд тулгуурлан техникийн туслалцаа үзүүлнэ.

Техникийн туслалцааны ихэнх хэсгийн Канадын мэргэжилтэн, зөвлөхүүд үзүүлэх ба шаардлагатай тохиолдолд бусад улсын зөвлөхүүдийг оролцуулдаг. Канадын засгийн газрыг төлөөлөн Cowater international байгууллага болон Канадын Төрийн удирдлагын хүрээлэн хамтран СТИФ-ийг хэрэгжүүлдэг.

*Сангийн хөрөнгийн хэмжээ:* 11.6 сая канад доллар (2018–2025)

*Хамрах хүрээ:* Хөгжлийн албан ёсны туслалцаа (ODA)-нд хамрагдах боломжтой Ази, Номхон далайн аль ч улсад байрладаг бүс нутгийн олон талт байгууллагууд

Ази Номхон далайн орнуудын аль нэгэнд байрладаг үндэсний төрийн байгууллагууд, худалдаа, аж үйлдвэрийн холбоод эсвэл иргэний нийгмийн байгууллагууд

*Гол зорилтот салбар, чиглэл:*

- Тогтвортой, хүртээмжтэй өсөлтийг дэмжих
- Эмэгтэйчүүдийн эдийн засгийн чадавхыг бэхжүүлэх

*СТИФ-ийн техникийн туслалцаа нь доорх үйл ажиллагааг хэрэгжүүлнэ. Үүнд:*

- Зөвлөх үйлчилгээ
- Сургалт

- Туршлага судлах аялал
- Бодлогын судалгаа
- Байгууллагыг бэхжүүлэх
- Талуудын оролцоог нэмэгдүүлэх

*Санхүүжилтийн хэмжээ:* 200,000 канад доллар хүртэл

*Хугацаа:* 6–12 сар

*Өргөдөл хүлээн авах хугацаа:* Хүссэн үедээ хандах боломжтой

*Жендэрийн шалгуур:* Төслүүд нь Канадын Феминист олон улсын тусламжийн бодлого (FIAP) болон доор дурдсан үр дүнгүүдийн дор хаяж нэгтэй нь уялдах ёстой.

- Ази, Номхон далайн бүс нутагт уур амьсгалд ухаалаг, жендэр болон нийгэмд хүртээмжтэй өсөлт, өрсөлдөх чадвар, эдийн засгийн интеграцлалыг дэмжих бүс нутгийн байгууллагуудын чадавхыг сайжруулах,
- Үндэсний болон орон нутгийн засаг захиргааны уур амьсгалд ухаалаг, жендэр болон нийгэмд хүртээмжтэй худалдаа, хөрөнгө оруулалтыг дэмжих бодлого, хууль тогтоомж, зохицуулалтыг төлөвлөх, боловсруулах, хэрэгжүүлэх, хэмжих чадварыг нэмэгдүүлэх,
- Уур амьсгалд ухаалаг, жендэр болон нийгмийн хүртээмжтэй худалдаа, дэд бүтэц, хөрөнгө оруулалтын асуудлаар иргэний нийгэм, хувийн хэвшлийн засгийн газартай хамтран ажиллах чадавхыг нэмэгдүүлэх,
- Бизнесийн өсөлт, эмэгтэйчүүдийн эдийн засгийг чадавхыг бэхжүүлэх, зах зээлийн хүртээмж, санхүүгийн хүртээмж болон хариуцлагатай бизнесийн ёс зүйг дэмжих иргэний нийгмийн болон хувийн секторын байгууллагуудын чадавхыг нэмэгдүүлэх

## 6. Ил тод байдлын чадавх бэхжүүлэх санаачилга (CBIT)

CBIT нь Парисын хэлэлцээр болон түүний ил тод байдал, хариуцлагын гол тулгууруудыг амжилттай хэрэгжүүлэхэд Дэлхийн Байгаль Орчны Сан (GEF)-гаас үзүүлж буй нэгэн төрлийн дэмжлэг юм. Жишээлбэл CBIT-ийн үйл ажиллагаа нь НҮБ-ын Уур амьсгалын өөрчлөлтийн суурь конвенц (UN-FCCC)-ийн дагуу тайлагнах үүргээ биелүүлэхэд нь хөгжиж буй орнуудад туслах ба энэ нь GEF-ийн зорилготой уялдаж

байгаа юм. Парисын хэлэлцээрийн үеэр CBIT-г байгуулахад дэмжлэг үзүүлэхийг GEF-ээс хүссэн ба өндөр хэмжээний доноруудын дэмжлэг, улс орнуудын оролцоо болон бус гол оролцогч талуудтай амжилттай хамтран ажилласны үр дүнд COP21 уулзалтаас 1 жилийн дотор CBIT-г байгуулсан. CBIT нь GEF-7 буюу 2018–2022 онд хэрэгжих GEF-ийн уур амьсгалын өөрчлөлтийн дэмжлэгийн нэг хэсэг ба төслүүд нь GEF-ийн итгэлцлийн сангаас санхүүжилт авдаг.

*Санхүүжүүлэгч:* GEF Сангийн хэмжээ: 2022 оны 3-р сарын 31-ний өдрийн байдлаар CBIT төслийн багцад нийт 130.8 сая ам.долларын 81 төсөл багтсан ба үүнд улс орнуудын 75 төсөл, бүс нутгийг хамарсан нэг төсөл, дэлхийг хамарсан 5 төсөл тус багтсан байна.

*Хамрах хүрээ:* Үндэсний хэмжээний төрийн байгууллага

*Уур амьсгалын зорилт:* Уур амьсгалын өөрчлөлтөд дасан зохицох, сааруулах ба тэдгээрийн давхцал үйл ажиллагаанууд

*Санхүүжилтийн механизм:* Буцалтгүй тусламж, батлан даалт

*Гол зорилтот салбар, чиглэл:* Мэдлэг хуваалцах, зохицуулах, чадавх бэхжүүлэх нэмэлт үйл ажиллагааг зохицуулах

*Хамтын санхүүжилтийн шаардлага:* CBIT нь Дэлхийн байгаль орчны сан (GEF)-гийн Хамтын санхүүжилтийн бодлого 30-ын дагуу хэрэгжинэ.

*Өргөдөл хүлээн авах хугацаа:* Хүссэн үедээ хандах боломжтой.

Төслийн үйл ажиллагаа нь GEF-ийн бодлого, журмуудын дагуу явах ба бүрэн хэмжээний төслийн шийдвэрийг GEF Зөвлөл гаргах бол дунд хэмжээний төслийн шийдвэрийг GEF-ийн гүйцэтгэх захирал гаргана.

*Жендэрийн шалгуур:* CBIT-ийн төслүүд нь GEF-ийн жендэрийн бодлог 31-ын дагуу хэрэгжинэ.

## 7. Дэлхийн уур амьсгалын түншлэлийн сан (GCPF) техникийн туслалцааны сан

GCPF-ийн Техникийн туслалцааны сан нь энэ зах зээлийн тогтвортой хөгжлийг дэмжихийн тулд түнш байгууллагуудын ногоон зээлийн үйл ажиллагааг дэмждэг. Техник туслалцааны сан нь эрчим хүчний хэмнэлт, сэргээгдэх эрчим хүчний төслүүдийн санхүүжилтийг эхлүүлэхэд тулгарч буй гол сорилтуудыг даван туулахад тусалдаг. Техник туслалцааны сан нь уур амьсгалын нөлөөллийг бууруулахад чиглэсэн хөрөнгө оруулалтыг дүгнэхэд шаардагдах чадавхыг нэмэгдүүлэх,

эрчим хүчний хэмнэлт, сэргээгдэх эрчим хүчний төслүүдийг санхүүжүүлэх боломжийг тодорхойлох, ашиглах боломжийг бүрдүүлэхийн тулд түнш байгууллагуудад мэргэшсэн зөвлөх үйлчилгээ авах боломжийг олгох замаар GCPF-ийн хөрөнгө оруулалтыг нөхөж өгдөг. Техник туслалцааны сан нь дараах зүйлсийг боловсруулж хэрэгжүүлэхэд дэмжлэг үзүүлдэг. Үүнд:

- Ногоон зээлийн чадавх бэхжүүлэх: Тусгайлан томилогдсон зөвлөхүүд нь санхүүгийн байгууллагуудад GCPF стандартад нийцсэн цэвэр эрчим хүчний зээлийн бүтээгдэхүүн, түүний дотор үр дүнтэй маркетинг, борлуулалтын стратеги боловсруулж хэрэгжүүлэхэд тусалдаг.
- Байгаль орчин, нийгмийн удирдлагын систем (ESMS): Техник туслалцааны сан нь түнш санхүүгийн байгууллагуудад GCPF-ийн байгаль орчин, нийгмийн стандартыг дагаж мөрдөх БОНУС-ээ нэвтрүүлэх, тасралтгүй сайжруулах, хэрэгжүүлэхэд тусалдаг.
- Нөлөөллийн үнэлгээний хэрэгсэл: Зээлийн CO<sub>2</sub>-ийн ул мөрийг хэмжих найдвартай суурь үзүүлэлт байхгүй тохиолдолд техник туслалцааны сан нь түнш байгууллагуудад цэвэр эрчим хүчний төсөл, нийгмийн стандартад хамрагдах эрхийн үнэлгээг хийхэд туслах суурь судалгааг захиалж болно.



# КОМПАНИЙН ЗАСАГЛАЛ, КОМПЛАЙНС

## ОЛОН УЛСЫН ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН ДЭРГЭДЭХ АУДИТЫН ХОРОО

### АУДИТЫН ХОРОО

Аудитын хороо нь компанийн санхүүгийн тайлагналын үйл явцад хяналт тавих үүрэг бүхий компанийн төлөөлөн удирдах зөвлөл (ТУЗ)-ийн дэргэдэх хороо юм.


Аудитын хороо нь үр дүнтэй ажиллахын тулд компанийн үйл ажиллагаа болон дотоод хяналтын талаарх мэдлэг, мэдээлэлтэй байх шаардлагатай бөгөөд нягтлан бодох бүртгэлийн зарчим, бодлого, хууль тогтоомжийн хэрэгжилтийг хангах чиглэлээр компанийн удирдлагын баг, хөндлөнгийн аудитор болон дотоод аудиторуудтай нягт уялдаа холбоотой ажиллах хэрэгтэй.

### Аудитын хорооны дүрэм, журам

Сарбанес–Оксли (2002)-ийн хуулийн дагуу АНУ-ын Үнэт цаас, биржийн хороо (SEC)-ноос биржид үнэт цаасаа бүртгүүлэхэд шаардагдах дүрэм, журмыг баталсан байдаг. Тус шаардлагад:

- Аудитын хороо нь хараат бус гишүүдээс бүрдэх;
- Аудитын хороо нь компанийн хараат бус аудиторыг сонгон шалгаруулж, түүнд хяналт тавих үүрэгтэй байх;
- Хөндлөнгийн, хараат бус аудиторт нөхөн төлбөр олгодог байх;
- Аудитын хороонд хөндлөнгийн зөвлөх үйлчилгээ авах эрхийг олгох;
- Нягтлан бодох бүртгэлийн үйл ажиллагаатай холбоотой гомдлыг хянан шалгах;

### Аудитын хорооны үүрэг, хариуцлага




1. Санхүүгийн тайланд дүн шинжилгээ хийж, дүгнэлт гаргах бөгөөд санхүүгийн тайлангийн талаарх ТУЗ-ийн мэдэгдэл компанийн нягтлан бодох бүртгэл, дүрэм журамд нөлөөлөх нөлөөг мөн хянадаг.
2. Хөрөнгө завших, авлига, санхүүгийн залилан гэх мэт залилангийн гэмт хэргээс урьдчилан сэргийлэх, илрүүлэхэд чиглэсэн бодлого боловсруулж, санхүүгийн залилан, сэжигтэй тохиолдол гарах үед шаардлагатай арга хэмжээг авахын тулд компанийн удирдлагатай хамтран ажилладаг.
3. Авлигатай тэмцэх хууль тогтоомжийн хариуцлагын талаарх мэдлэгтэй, түүнтэй холбоотой эрсдэлийг илрүүлэх, бууруулахад чиглэсэн бодлогын хэрэгжилтэд хяналт тавих ёстой.
4. Аудитын хорооны хуралд компанийн удирдлага болон хараат бус аудиторыг оролцуулан, улирлын болон аудитаар баталгаажуулсан жилийн санхүүгийн тайланг хэлэлцдэг бөгөөд орлогын мэдээ болон санхүүгийн дэлгэрэнгүй мэдээлэл, гаднын үнэлгээний байгууллага, шинжээчдийн өгсөн зөвлөмжид дүгнэлт гаргадаг.
5. Удирдлагын баг нь компанид учирч буй эрсдэлийг үнэлж, удирдах үүрэгтэй бөгөөд аудитын хороо компанийн эрсдэлийг хянах талаар бүх ачааллыг хүлээх боломжгүй. Тэд бодлого боловсруулах, хянах үүрэгтэй ба зарим байгууллагын хувьд аудитын хороо нь кибер эрсдэлийн хяналтыг хариуцдаг байна.
6. Бусад компанитай нэгдэх болон худалдан авах үйл ажиллагааны явцад аудитын хороо нь компанийн санхүү, дотоод хяналт, эрсдэлийн шинжилгээ, санхүүгийн мэдээллийн үнэн зөв байдалд дүгнэлт хийдэг. Цаашилбал, Сарбанес–Окслийн хуулийн дагуу Үнэт цаасны биржийн хорооны дүрэмд заасны дагуу компаниуд нэгдсэний дараа санхүүгийн тайлангийн болон ил тод байдлын хяналтыг үр дүнтэй нэгтгэн уялдуулах шаардлагатай бөгөөд үүнийг хэрэгжүүлж чадаагүй нөхцөлд хяналтын зарчим алдагдах эрсдэлтэй байдаг. Аудитын хороо бусад компанитай нэгдэх болон худалдан авах үйл ажиллагааг амжилттай хэрэгжүүлэх зорилгоор харилцан уялдаа холбоог хангах үүрэгтэй.
7. Хараат бус аудиторыг томилж, үйл ажиллагаанд нь хяналт тавьж, нөхөн төлбөр олгох асуудлыг зохицуулдаг.
8. Зарим үнэт цаасны биржүүдээс Аудитын хороог дотоод аудиторуудын үйл ажиллагаанд хяналт тавьж, гүйцэтгэлийг нь үнэлж, тайланг ТУЗ–д танилцуулж байхыг шаарддаг. Аудитын хороо нь дотоод аудиторуудтай тус тусад нь уулзаж, хараат бус байдлыг ханган ажиллах шаардлагатай.
9. Компанийн удирдлагуудтай хамтран ажиллаж, ёс зүйн дүрэм, зарчим, баримталж буй бодлогын хэрэгжилтэд хяналт тавих үүрэгтэй.
10. Аудитын хороо нь аливаа эрсдэлээс сэргийлэх зорилгоор бусад хороодтой хамтран ажиллах шаардлагатай. Эрсдэлийн үнэлгээ, түүнд холбогдох зардалд нягтлан бодох бүртгэлээс гадна бусад арга хэмжээний үзүүлэх нөлөөллийг үнэлж, түүний талаар ойлголттой байх шаардлагатай.

#### Дүгнэлт

- Аудитын хороо нь компанийн санхүүгийн тайлан, түүнтэй холбогдох эрсдэл, дотоод хяналт, дүрэм, журмын хэрэгжилт, ёс зүйг удирдан чиглүүлдэг.
- Нягтлан бодох бүртгэлийн зарчим, бодлогод нийцсэн санхүүгийн тайлан гаргахын тулд компанийн удирдлага, аудиторуудтай хамтран ажиллах ёстой.
- Санхүүгийн тайланг үнэн зөв гаргахын тулд аудитын хороо нь компанийн удирдлагаас хэрэгжүүлж буй үйл ажиллагаа, дотоод хяналтын талаар мэдлэг, мэдээлэлтэй байх ёстой.
- Аудитын хороо нь бие даасан аудиторыг сонгон томилж, тэдний ажлын үр дүнг үнэлж, нөхөн олговрыг шийдвэрлэх үүрэгтэй. Зарим компанийн хувьд аудитын хороо нь дотоод аудиторуудын үйл ажиллагааг мөн хянадаг.

## ФИНТЕК БА РЕГТЕК

### ДИЖИТАЛ ХӨРӨНГӨ БОЛОН ТОКЕНЖУУЛАЛТЫН ТАЛААР МЭДЭХ ЁСТОЙ 5-Н ЗҮЙЛС



#### 1 КРИПТО БИРЖЭЭР АРИЛЖААЛАГДДАГ САН /ETF/-ИЙН ХАЛДВАР

Удаан хугацаанд хүлээсний эцэст АНУ-ын Үнэт цаас биржийн хорооноос 2024 оны 1 дүгээр сараас 3 дугаар сарын хооронд ирсэн 10 Биткойны ETF (Bitcoin ETF)-н хүсэлтийг зөвшөөрөв. 2024 оны 1 дүгээр сарын шийдвэрийн дараа, ХонгКонг-д биткойн болон Ether ETF, Австралид Monochrome Bitcoin ETF, Тайландад ONE Bitcoin ETF, Английн Санхүүгийн зохицуулах байгууллагаас биткойн болон Лондоны хөрөнгийн биржид бүртгэлтэй Ethereum ETP, Wisdom Trees Physical Bitcoin (BTCW) Physical Ethereum (ETHW) ETPs тус тус зөвшөөрөв.

#### 2 ӨӨРИЙН БАНКААРАА КРИПТОГ ХУДАЛДАХ, ХУДАЛДАН АВАХ БОЛОМЖ

Их Британид төвтэй үндэстэн дамнасан Standard Chartered (StanChart) банк 6 дугаар сард Лондон хотод крипто арилжаа

хийж байгаагаа зарласан бөгөөд удахгүй биткойн болон Ether-ийн арилжаа хийх хүсэлтэй үйлчлүүлэгчдэд нээлттэй болох юм. StanChart багийн эхлүүлсэн энэ ажил нь магтах ёстой зүйл юм, учир нь ихэнх банкнууд крипто арилжаатай холбоотой бүх зүйлээс татгалздаг.

Үйлчлүүлэгчид Revolut, Monzo, Juno зэрэг финтек необанкнуд биржээр дамжуулан крипто арилжаанд оролцох боломжтой ч StanChart банк арилжааг эхлүүлсэн нь анхны томоохон (зохицуулалттай) санхүүгийн байгууллага крипто спот зах зээл дээр арилжаа явуулж үйлчилгээ үзүүлж буй томоохон үйл явдал юм.

#### 3 ТОКЕНЖУУЛСАН ӨР ТӨЛБӨР

HSBC банкнаас Хонг Конгийн Мөнгөний Газарт 740 сая ам.долларын ногоон бонд гаргасан нь анхны олон валюттай дижитал бондын гаралт бөгөөд дэлхийн тогтмол орлоготой

нийгэмлэгийн олон хүмүүсийн анхаарлыг татсан, өнөөг хүртэл гарсан дэлхийн хамгийн том дижитал бонд юм.

Европын хөрөнгө оруулалтын банкнаас сүүлийн 18 сарын хугацаанд жижиг хэмжээний Euroclear, Goldman Sachs, SocGen, Santander болон бусад дижитал бонд гаргасан. JP Morgan нь АНУ-ын дижитал хотын бондыг хөрөнгө оруулагчдад хүргэхийн тулд өөрийн Опух платформыг ашиглаж байгаа нь санхүүгийн оролцоог нэмэгдүүлэх замаар нийгэмд чухал шинэлэг зүйл болж байна.

## 4 ТОГТВОРТОЙ КОЙН – WEB3 ДИЖИТАЛ МӨНГӨ

Дэлхийн хамгийн том тогтвортой койн гаргагч зах зээлийн 70 хувийг эзэлдэг Tether-ийн I, II, III улирлын ашиг нь Goldman's Sachs-ыг давсан бөгөөд 6 дугаар сард алтаар баталгаажсан шинэ тогтвортой койн гаргахаа зарлав. Дэлхийн макро эдийн засаг, улс төрийн тогтворгүй байдлын үед алтаар баталгаажуулсан дижитал мөнгө нь хүмүүсийн дунд түгээмэл байна.

Энэ долоо хоногт Circle MICA-д нийцсэн анхны тогтвортой койн гаргасан нь Европ дижитал хөрөнгө болон Web3-т зориулж дижитал төлбөрийн сүлжээгээ бэлдэж байгааг харуулж байна. Circle Францын банкны зохицуулах байгууллага болох Autorité de Contrôle Prudentiel et de Résolution (ACPR)-аас Цахим мөнгөний байгууллагын (EMI) тусгай зөвшөөрлийг авсан. USDC болон EURC нь одоо Европын зах зээлд ашиглах болон төлөх боломжтой боллоо.

PayPal болон SocGen тогтвортой койны зах зээлд орсноор банкнууд болон хадгаламжийн койнуудад шахалтыг үзүүлж байна. Хадгаламжийн койн нь JPM Coin гэх мэт гаргагчийн эсрэг хадгаламжийн нэхэмжлэхийг нотлох, тусгай зөвшөөрөлтэй хадгаламжийн байгууллагын блокчейн дээр гаргасан токен руу шилжүүлэх боломжтой юм.

Олон улсын төлбөр тооцооны банкны (BIS) Инновацын төв нь 5 дугаар сард хил дамнасан төлбөрийг токенжуулахад чиглэсэн төрийн болон хувийн хэвшлийн хамтын санаачилга болох Project Agora-г зарласан. Энэ нь технологийн шинийг санаачлагчдад төв банкнууд болон технологийн хамтын ажиллагаанд үр дүнтэй арга юм.

## 5 ДЭЛХИЙ ДАЯАР ДИЖИТАЛ ЗАХ ЗЭЭЛИЙГ ЧИГЛҮҮЛЭХ БА ХОЛБОХ

GDF нь FIX Trading Community-тай хамтран шинэ санаачилгыг эхлүүлэх Joint Working Group-ыг байгуулах тухайгаа зарлажээ. Энэ нь уламжлалт санхүү ба дижитал үнэт цаасны хоорондын мэдээллийн солилцоог хийхэд зориулагдсан бөгөөд FIX Протокол болон FinP2P Tokenization холболтын давуу талуудыг ашигладаг. FIX нь биржүүд болон хөрөнгийн зах зээлийг холбох стандарт бөгөөд DLT (Distribution Ledger Technology) орчинд тусгайлсан хөрөнгийг Token Islands-оос салгах зайлшгүй шаардлагатай хэрэгсэл юм.

Энэ долоо хоногт Digital Asset (DA) Canton Network-ийн Global Synchronizer хэмээх программыг зарлалаа. Canton Network нь 80-аас олон байгууллагын сүлжээ юм. Global Synchronizer нь Canton Network-ийн анхны төвлөрсөн бус дэд бүтцийн шийдэл бөгөөд сүлжээнд нэмэлт дэд бүтэц хөгжүүлэхээр ажиллаж байна. Байгууллагууд баталгаажуулалт хийх, Global Synchronizer Foundation-д нэгдэх, мөн сүлжээнд программ ажиллуулах боломжтой.

# СУДЛААЧИЙН ИНДЭР

## САНХҮҮГИЙН ХЯНАЛТ ШАЛГАЛТ ДАХЬ ТЕХНОЛОГИЙН ХЭРЭГЛЭЭ: ЖИШЭЭ, ЗӨВЛӨМЖ

Эхлэл 1–р нүүрт

Энэхүү судалгааны ажилд дурдагдсан санал, дүгнэлт нь зөвхөн хувь судлаачдын байр суурийг илэрхийлэх бөгөөд Санхүүгийн зохицуулах хорооны албан ёсны байр суурийг илэрхийлэхгүй болно.

### Гүйцэтгэсэн:

Б.Батчимэг, СЗХ, ЗЗСХГ, Сэндбоксын албаны дарга, [batchimeg\\_b@frc.mn](mailto:batchimeg_b@frc.mn)

Г.Анхзаяа, СЗХ, ЗЗСХГ, Сэндбоксын албаны мэргэжилтэн, [ankhzaya\\_g@frc.mn](mailto:ankhzaya_g@frc.mn)

О.Мичидмаа, СЗХ, ЗЗСХГ, Сэндбоксын албаны мэргэжилтэн, [michidmaa\\_o@frc.mn](mailto:michidmaa_o@frc.mn)

### УДИРТГАЛ

#### Санхүүгийн хяналт, шалгалтын технологийн хувьсал

Суптекийн хөгжил нь санхүүгийн зохицуулагч байгууллагууд өөрсдийн хяналт, шалгалтын үйл ажиллагаандаа дижитал хэрэгслүүдийг ашиглах боломжийг эрэлхийлж эхэлсэн 2000–аад оны эхэн үеэс улбаатай. Хөгжлийн эхэн үедээ зохицуулагч байгууллагууд цаасан тайланг электрон хэлбэрээр хүлээн авах зэрэг үйл ажиллагаанд төвлөрч байсан бол 2008 оны санхүүгийн хямрал нь уламжлалт хяналт, шалгалтын үйл ажиллагааны хязгаарлагдмал байдлыг ойлгуулж, санхүүгийн системийг үр дүнтэй хянаж, зохицуулахын тулд илүү боловсронгуй технологийг ашиглах шаардлагатайг харуулсан.

Санхүүгийн зах зээлийн хямралын дараагаар санхүүгийн системийн эрсдэлийг эрт илрүүлэх, бодит цагийн хяналт тавих технологийг хөгжүүлэхэд илүү анхаарал хандуулж эхэлсэн бөгөөд тус үйл явц нь суптекийн хөгжлийн нэгдүгээр үе шатад хамаарч буй бөгөөд энгийн өгөгдлийн шинжилгээг гүйцэтгэх, өгөгдлийн чанарыг баталгаажуулах үйл ажиллагааг автоматжуулах зэрэг шинэчлэлүүд хийгдэж эхэлсэн. Өнгөрсөн арван жилийн дотор хиймэл оюун ухаан, машин сургалт болон их өгөгдлийн шинжилгээ зэрэг технологийн хөгжлийн нөлөөгөөр суптекийн хэрэгслүүд үсрэнгүй хөгжсөн. Өнөөдрийн байдлаар суптек нь автоматжуулсан тайлагналын системээс эхлээд хиймэл оюун ухаанд суурилсан зах зээлийн хяналт, блокчэйн суурьтай гүйлгээний хяналт зэрэг маш өргөн хүрээний технологийн хэрэглээг хамруулсан цогц ойлголт болон хөгжиж байна.

Англи Улсын Санхүүгийн зохицуулагч байгууллага, Сингапурын Төв банк, Европын холбооны Төв банк зэрэг

дэлхийд тэргүүлэх санхүүгийн системийн зохицуулагч байгууллагууд суптекийн хөгжлийн тэргүүнд алхаж байна. Эдгээр байгууллагууд нь хяналт, шалгалтын үйл ажиллагаагаа сайжруулах, зах зээлийн ил тод байдлыг нэмэгдүүлэхийн тулд төрөл бүрийн инновац, технологийн хэрэгслүүд, платформуудыг ашиглаж байна. Амжилттай хэрэгжиж буй эдгээр төслүүд нь суптекийн ач холбогдлыг улам бүр тодотгож, цаашдын хөрөнгө оруулалт, зах зээлийн томоохон зах зээл тус салбарт буйг харуулж байна.

Суптек хөгжихийн хэрээр түүний хэрэглээ нь уламжлалт хяналт, шалгалтын үйл ажиллагаанаас халин кибер аюулгүй байдал, мөнгө угаахтай тэмцэх үйл ажиллагааг, санхүүгийн гэмт хэрэг, луйврыг илрүүлэх зэрэг шинэ салбаруудыг хамрах болсон.

#### Судалгааны зорилго, хамрах хүрээ

##### Судалгааны зорилго

Манай улсын хувьд бодит цагийн хяналт, эрсдэлийн динамик үнэлгээний систем хараахан хөгжөөгүй байгаа нь зах зээлд оролцогчдын итгэлийг бууруулах, улам бүр нэмэгдэж буй системийн эрсдэлийг дутуу үнэлэх, эрсдэлийг хугацааны хоцрогдолтойгоор таних зэрэг сул талыг үүсгэж байна. Мөн дэлхий дахинаа улс орнуудын санхүүгийн системд хяналт, шалгалтын технологи эрчимтэй нэмэгдэж буй өнөөгийн нөхцөлд Монголын санхүүгийн салбар өрсөлдөх чадвараа хадгалах, хөрөнгө оруулалт татахад бэрхшээлтэй тулгарч магадгүй юм. Финтекийн салбарын хурдацтай өсөлт, шинэчлэлт нь зохицуулалтын орчныг улам нарийн цогц

байхыг шаардаж буй нь суптекийн хөгжилтэй хөл нийлүүлэн алхахыг шаардаж байна.

Суптекийг ашигласнаар зохицуулагч байгууллагуудын эрсдэлийн удирдлага, хяналт, шалгалтын чадавхыг сайжруулж, боловсон хүчний ажлыг хөнгөвчлөхөөс гадна, байгууллагын үйл ажиллагааны үр ашигт байдлыг нэмэгдүүлэн, санхүүгийн тогтвортой байдлыг нэмэгдүүлэх боломжтой. Энэхүү судалгааны үндсэн зорилго нь санхүүгийн хяналт, шалгалт дахь технологийн боломжит хэрэглээ, улс орнуудын хэрэгжүүлж буй жишээг судлах, үүнд үндэслэн Санхүүгийн зохицуулах хорооны үйл ажиллагаанд суптекийг нэвтрүүлэх боломжийг судлах юм.

### Судалгааны хамрах хүрээ

Энэхүү судалгаа нь суптекийн хэрэглээ хамгийн их шаардлагатай хяналт, шалгалтын үйл ажиллагааны дараах үе шатуудыг хамарна. Үүнд:

Өгөгдөл цуглуулалт, өгөгдлийн шинжилгээ: суптек нь хэрхэн өгөгдөл цуглуулах, өгөгдлийн чанарыг сайжруулах, бодит цагийн өгөгдлийн шинжилгээг бодлого, зохицуулалтын шийдвэр гаргалтад ашиглах зэрэг үйл ажиллагааг хэрхэн сайжруулж буй автоматжуулж буй талаарх жишээ, судлагдахуун;

Зохицуулалтын комплаенс: комплаенсын үйл ажиллагааг хялбарчлах, санхүүгийн байгууллагуудад очих хяналт, шалгалтын үйл ажиллагааны дарамт, ачааллыг бууруулах, комплаенсын хяналт, тайлагналын үр дүнг нэмэгдүүлэх жишээ, судлагдахуун;

Эрсдэлийн менежмент, эрсдэлийг бууруулах үйл ажиллагаа:

таамаглалын шинжилгээ, хиймэл оюунд суурилсан загварчлал болон бусад төрлийн суптек шийдлүүд санхүүгийн систем дэх эрсдэлийг хэрхэн илрүүлж, бууруулж буй талаарх жишээ, судлагдахуун

Зохистой байдлын хяналт, шалгалт: зах зээлийн үйл ажиллагааг хянах, зах зээлийг гажуудуулсан үйл ажиллагааг илрүүлэх, зах зээлийн тогтвортой, нэгдмэл байдлыг нэмэгдүүлэхэд суптекийг хэрхэн хэрэгжүүлж буй талаарх жишээ, судлагдахуун

Хэрэглэгчийг хамгаалах үйл ажиллагаа: автоматжуулсан гомдол шийдвэрлэлтийн механизм, сэтгэл хөдлөлийн шинжилгээ зэрэг аргачлалуудыг ашиглан хэрэглэгчийг хамгаалах үйл ажиллагааг хэрхэн сайжруулж буй талаарх жишээ, судлагдахуун

Жишээ судлагдахуун, зөвлөгөө: суптекийг хэрэгжүүлж буй зохицуулагч байгууллагуудын кэйс судлагдахууныг судлан, Санхүүгийн зохицуулах хороонд суптекийг нэвтрүүлэх, зөвлөмж хүргүүлэх.

Энэхүү судалгаа нь дээрх агуулгын хүрээн дэх жишээ, загварыг судалснаар санхүүгийн хяналт шалгалт дахь суптекийн хэрэглээг нэгдмэл байдлаар харах, үүнд үндэслэн Монгол Улсад хэрэгжүүлэх шаардлагатай арга, хэмжээг тодорхойлоход шаардлагатай мэдээлэл боловсруулахыг зорилоо. Судалгаа нь санхүүгийн хяналт, шалгалт дахь суптекийн хэрэглээ, кэйс судалгаа, Монгол Улсын санхүүгийн хяналт, шалгалтын өнөөгийн нөхцөл байдал, Санхүүгийн зохицуулах хороонд хяналт, шалгалтын үйл ажиллагааг нэвтрүүлэх санал, зөвлөмж, дүгнэлт гэсэн бүлгүүдээс бүрдэнэ.

## САНХҮҮГИЙН ХЯНАЛТ, ШАЛГАЛТ ДАХЬ СУПТЕКИЙН ХЭРЭГЛЭЭ

Суптек нь санхүүгийн хяналт, шалгалтын үйл ажиллагааны үе шат бүрд хэрэглэгдэн хяналт, зохицуулалтын үйл ажиллагааны үр дүнг нэмэгдүүлж буй бөгөөд тус бүлэгт суптекийн хэрэглээ болон тэдгээрийг улс орнуудын санхүүгийн зохицуулагч байгууллагууд хэрхэн ашиглаж буй жишээг судална.

Өгөгдөл цуглуулалт, өгөгдлийн шинжилгээ

Санхүүгийн зохицуулагч байгууллагууд хяналтын чиг үүргээ гүйцэтгэхэд чанартай тоон мэдээлэл, тайлан хамгийн чухал. Гэсэн хэдий ч зохицуулагч байгууллагын хувьд санхүүгийн байгууллагуудаас мэдээ, тайланг тогтмол хугацаанд хүлээн авч, алдаа зөрүүг нь тулган баталгаажуулах зэрэг үйл ажиллагаа нь цаг хугацаа, хянан шалгагчийн хөдөлмөрийг ихээр зарцуулсан зардал өндөртэй үйл ажиллагаа болдог.

Санхүүгийн байгууллагуудын тайлагналын үйл явц нь тэдний үйл ажиллагааны төрөл ямар байхаас үл хамааран дараах процессын дагуу явагддаг бөгөөд эхлээд санхүүгийн байгууллагууд өөрсдийн үйл ажиллагааны өгөгдлийг боловсруулах, үүний дараагаар зохицуулалтын байгууллагуудад өгөх тайлан, мэдээг бэлтгэх, зохицуулалтын байгууллагуудын шаардсан загварын дагуу тайлан, мэдээг засварлан боловсруулж, санхүүгийн зохицуулагч байгууллагад шилжүүлэх зэрэг процессыг туулдаг.

Зураг. Өгөгдөл цуглуулах үйл явцын зураглал



Өнөөдрийг хүртэлх хугацаанд санхүүгийн зохицуулагч байгууллагууд нь ихэвчлэн зохицуулагч байгууллагуудаас урьдчилан бэлдсэн маягтын дагуу шаардлагатай тайлан, мэдээллийг аван хяналт, шалгалтаа хэрэгжүүлж ирсэн. Гэхдээ санхүүгийн үйл ажиллагаа өргөжин тэлэхийн хэрээр тоон, мэдээллийн хэмжээг нэмэгдэх, мөн санхүүгийн шинэ төрлийн үйл ажиллагаа нэмэгдэн, зохицуулалтын байгууллагын тоо өсөх тутамд зохицуулагч болон зохицуулалтын байгууллагууд аль, алиных нь хувьд тайлан боловсруулах ажилд ихээхэн цаг хугацаа зарцуулах болсон. Харин сүүлийн жилүүдэд санхүүгийн зохицуулагч байгууллагууд уг тайлан, мэдээ илгээх үйл ажиллагааг хялбарчлах чиглэлд анхаарч эхэлсэн бөгөөд төрөл бүрийн суптекийн төслийг хэрэгжүүлж эхэлсэн. Санхүүгийн тайлагналын ирээдүйн чиг хандлагын хувьд санхүүгийн тайланг илгээх дээрх бүх процессын оронд зохицуулагч байгууллага өөрсдийн хяналт, шалгалтын үйл ажиллагаанд хэрэгцээтэй өгөгдөл, мэдээллийг санхүүгийн байгууллагын мэдээллийн талбараас шууд татах хэлбэрт шилжинэ гэж таамаглаж байна. Зохицуулагч байгууллагууд шаардлагатай тоон өгөгдлийг шууд татах уг үйл ажиллагааг хэрэгжүүлэхийн тулд санхүүгийн байгууллагуудын эхний шатанд боловсруулагдаж буй үйл ажиллагааны өгөгдөлд нь тодорхой стандартуудыг нэвтрүүлэх шаардлагатай.

### Суптекийн гол хэрэглээ

**Автоматжуулсан өгөгдлийн тайлагнал:** суптекийн шийдлүүд нь санхүүгийн байгууллагуудаас өгөгдөл цуглуулах үйл ажиллагааг автоматжуулж буй бөгөөд ингэснээр гар ажиллагааг бууруулж, хүнээс шалтгаалан гарах алдааг багасгаж байна.

**Их өгөгдлийн шинжилгээ:** их өгөгдлийн шинжилгээг ашигласнаар зохицуулагч байгууллагууд арилжааны мэдээлэл, зах зээлийн өгөгдөл, нийгмийн сүлжээ зэрэг олон тооны ялгаатай эх үүсвэрүүдээс их хэмжээний өгөгдлийг аван ашиглах боломжтой болсон. Энэ нь зөвхөн санхүүгийн байгууллагуудын тайлан, мэдээллийг шинжилснээр тодорхойлогдох боломжгүй нуугдсан эрсдэлүүдийг тодорхойлох боломжийг олгож буй юм.

**Хиймэл оюунд суурилсан шинжилгээ:** хиймэл оюун болон машин сургалтын алгоритмууд нь их хэмжээний өгөгдлийг ашиглан таамаглалын шинжилгээний чадавхыг нэмэгдүүлж байна. Тус технологийн тусламжтайгаар зохицуулагч байгууллага зах зээлийн трендийг таамаглах, эрсдэлийг үнэлэх мөн системийн хэмжээний эрсдэл учруулж болзошгүй үйл ажиллагаа, оролцогчдыг таних боломж бүрдсэн.

### Суптек ашиглагдаж буй жишээ

**Америкийн Нэгдсэн Улс:** Хадгаламжийн даатгалын агентлаг

**Төслийн нэр:** Streamlined Data Collection

**Технологи:** Advanced data collection, RPA, Dashboard

АНУ-ын Хадгаламжийн даатгалын агентлаг нь зохицуулалтын байгууллагуудын тайлан гаргах үйл явцыг цаг алдалгүй, ачаалал багатай болгох, мэдээлэл цуглуулах шинэ шийдлүүдийг судлах зорилгоор Текспринт уралдааныг зохион байгуулсан. АНУ урт хугацаандаа зохицуулалтын байгууллагуудаа санхүүгийн тайлангаар хянахын оронд шаардлагатай тайлан, мэдээллээ тухай бүрд нь татах замаар

хянах системд шилжихийг зорьж буй бөгөөд уг төсөл нь энэхүү урт хугацааны төлөвлөгөөт ажлынх нь эхлэл болж буй юм. Тус төслийн хувьд харьцангуй жижиг хэмжээтэй, олон нийтийн банкнуудад зориулан боловсруулж буй бөгөөд энэ төрлийн банкнууд нь санхүүгийн нөхцөл байдлын тайлангаа зөвхөн улирал тутам нэгтгэл дүнгээр өгдөг байсан нь хямралын үед мэдээллийн зөрүүгээс үүдсэн эрсдэлийг үүсгэх эрсдэлтэй. Туршилтын шатандаа байгаа уг төсөл нь одоогийн байдлаар өгөгдөл дамжуулах шатыг хөгжүүлэхэд илүүтэй анхаарч буй хэдий ч тайлагналын үйл явц дахь бусад цэгүүдэд тухайлбал илүү нарийн мэдээллийг санхүүгийн байгууллагуудаас авах, илүү дэвшилтэт аналитик шинжилгээний технологийг нэвтрүүлэхэд мөн анхаарч буй.

**Танзани Улс:** Төв банк

**Төслийн нэр:** Non-intrusive Mobile Money (MM) data collection systems

**Технологи:** BI, Advanced data collection

Мобайл банкны үйлчилгээний найдвартай тайлан мэдээлэл дутмаг байсан нь санхүүгийн зохицуулагч байгууллага, хянан шалгагчдад тус хурдацтай хөгжиж буй зах зээлийн үр дүнтэй хянаж, үндэслэлтэй шийдвэр гаргахад хүндрэл учруулж байв. Танзани Улсын мобайл банкны үйлчилгээ үзүүлэгч бүрд хөндлөнгийн бус (non-intrusive) өгөгдөл цуглуулах системийг суурилуулж, холбогдох байгууллагуудыг зохицуулагч байгууллагуудын бизнес оюуны (BI) модуль бүхий өгөгдлийн сантай холбосон. Уг төслийн үр дүнд Танзанийн Төв банк нь Танзанийн Харилцаа холбооны зохицуулах газартай хамтран мобайл банкны гүйлгээг 100 хувь хянах боломжтой болсон.

**Европын Холбоо:** Төв банк

**Төслийн нэр:** Banks' Integrated Reporting Dictionary (BIRD)

**Технологи:** Dashboards

Европын холбооны Төв банк болон банкнууд өөр өөр загварчлалын арга зүйг ашиглан нэгтгэсэн өгөгдлийн бүтэц,

хамаарлыг тодорхойлох аргачлалд суурилсан банкнуудын нэгдсэн тайлангийн толь бичиг нэртэй системийг хамтран гаргасан. Тус систем нь банкнуудын дотоод үйл ажиллагааны системээс гаргаж авах шаардлагатай өгөгдлүүдийг нарийн тодорхойлох боломжийг олгодог. BIRD систем нь тоон өгөгдлийг шилжүүлж, баталгаажуулах стандарт хэлийг ашигладаг бөгөөд өгөгдлийн тайлагналын дүрмийг логиктой, технологи-агностик (өөр өөр төрлийн технологиудтай харилцан ажиллах) аргаар тодорхойлдог. Ингэснээр шаардлагатай өгөгдлийг автоматаар тооцоолох, шууд технологиор унших боломжтой дүрмийг гаргах боломжтой болдог бөгөөд тус төсөлд банкнууд сайн дурын үндсэн дээр оролцдог.

**Филиппин Улс:** Төв банк

**Төслийн нэр:** API, Back Office Reporting, and Visualisation

**Технологи:** Dashboards, Data validation, APIs

Филиппиний Төв банк, Зохицуулалтын технологийн хурдасгуур төв /R2A/-тэй хамтран өгөгдөл цуглуулах, баталгаажуулах үйл ажиллагаагаа сайжруулах тулд хэрэглээний программын интерфэйс болон арын оффисын тайлагнал, тайлан мэдээг боловсруулж, дүрслэх программыг боловсруулсан. Энэхүү хэрэгсэл нь зохицуулалтын тайланг банкны мэдээллийн сангаас шууд гаргаж, ХМ-д суурилсан нэг шифрлэгдсэн файл болгон хувиргаж, Филиппиний Төв банкны тоон өгөгдөл боловсруулах үе шат руу шилжүүлдэг. Тус өгөгдөл боловсруулах үйл ажиллагаа нь бодит цагийн горимоор ажилладаг бөгөөд хэвийн бус утга ажиглагдсан тохиолдолд автоматаар дохио өгдөг. Тус төсөлд мөн төвлөрсөн хэлбэрийн аюулгүй байдал хангагдсан хандалттай мэдээллийн сан, вебд суурилсан пивот хүснэгтийн хэрэгсэл, эрсдэлийн үзүүлэлтүүдийг дүрслэн харуулах диаграмм зэрэг бусад төрлийн аналитик хэрэгслүүд багтсан. Уг төсөл нь илүү сайн, цаг хэмнэсэн аналитик шинжилгээ хийх, илүү уян хатан тайлагнал, хяналт, шалгалтын үйл ажиллагааг нэвтрүүлж, илүү үр дүнтэй менежментийг бий болгосон.

## Зохицуулалтын комплаенс

Зохицуулалтын комплаенсын нь санхүүгийн байгууллагууд хууль, дүрэм, журмаа мөрдөн ажиллаж буй эсэхийг хянах, санхүүгийн системийн тогтвортой байдлыг хангах, хэрэглэгчийн эрх ашгийг хамгаалахад чухал үүрэгтэй. Комплаенсыг хангуулах уламжлалт үйл ажиллагаа нь цаг их шаардсан, гар ажиллагаа өндөртэй, хүнээс хамаарсан алдаа ихтэй байсан бол сүптек нь бодит цагийн комплаенсын хяналтыг хэрэгжүүлэх, тайлагналыг автоматжуулах, зохицуулагч байгууллагууд хоорондоо өгөгдлөө түргэн шуурхай солилцох зэрэг боломжийг олгож байна.

## Суптекийн гол хэрэглээ

**Бодит цагийн комплаенсын хяналт:** суптекийн хэрэгслүүд нь санхүүгийн байгууллагууд зохицуулалтын шаардлагуудыг хэрхэн хангаж буйд бодит цагийн хяналтыг үр дүнтэй хэрэгжүүлэх боломжийг олгож байна. Хяналт, шалгалтын автоматжуулсан системийг ашигласнаар зохицуулалтын шаардлагыг хангаагүй үйл ажиллагаанд улаан дохио өгөх зэргээр зохицуулагч байгууллага хугацааны хоцрогдолгүйгээр хяналтын чиг үүргээ үр дүнтэй хэрэгжүүлэх боломжтой.

**Автомат тайлагналын хэрэгсэл:** санхүүгийн байгууллагууд зохицуулагч байгууллагуудад тайлан мэдээллээ автоматаар тайлагнаснаар санхүүгийн байгууллагуудын ачааллыг бууруулах, зохицуулагч байгууллага шаардлагатай мэдээллийг цаг тухайд нь авах нөхцөлийг бүрдүүлж байна.

**Зохицуулалтын байгууллага хоорондын өгөгдөл солилцох платформ:** санхүүгийн зохицуулагч байгууллагууд, зах зээлийн оролцогчид өгөгдөл мэдээлэл солилцох платформыг хөгжүүлснээр зах зээлийн ил тод байдал, зохицуулалт, хяналтын давхардлыг арилгах зэрэг давуу талыг бий болгож байна.

## Суптек ашиглагдаж буй жишээ

**Америкийн Нэгдсэн Улс:** Санхүүгийн салбарын зохицуулагч байгууллага

**Төслийн нэр:** Consolidated Audit Trail

**Технологи:** BI, Cloud computing, Web portals, Advanced Data Collection

АНУ-ын Санхүүгийн зохицуулагч байгууллага нь Амазон веб үйлчилгээний үүлэн технологийг ашиглан нэгдсэн аудитын системийг хөгжүүлсэн бөгөөд тус систем нь санхүүгийн

## Эрсдэлийн менежмент, эрсдэлийг бууруулах үйл ажиллагаа

Эрсдэлийн менежмент, эрсдэлийг бууруулах үйл ажиллагаа нь санхүүгийн хяналт, шалгалтын хамгийн гол бүрдэл нь бөгөөд санхүүгийн байгууллагуудын найдвартай үйл ажиллагааг хангуулснаар санхүүгийн системийн тогтвортой байдлыг хамгаалдаг. Уламжлалт эрсдэлийн менежментийн үйл ажиллагаа нь ихэвчлэн түүхэн өгөгдөл, улирал тутмын үнэлгээнд суурилж ирсэн бөгөөд айсуу хямрал, эрсдэлийг оройтож илрүүлэх өндөр эрсдэлтэй байдаг. Суптекийн хэрэгслүүд нь таамаглан шинжлэх техник, стресс тест, эрт илрүүлэх системийг ашигласнаар эрсдэлийг таамаглах, эрсдэл тохиохоос өмнө урьдчилан сэргийлэх үйл ажиллагааг үр дүнтэй хэрэгжүүлэх боломжийг олгож байна.

## Суптекийн гол хэрэглээ

**Эрсдэлийг илрүүлэх таамаглалын шинжилгээ:** суптекийн хэрэгслүүд нь бодит эрсдэлийг урьдчилан таамаглахад ашиглагдаж буй бөгөөд түүхэн өгөгдөл болон зах зээлийн нөхцөл байдлыг шинжилснээр зохицуулагч байгууллагууд эрсдэлийг эрт илрүүлэн шаардлагатай арга хэмжээг хэрэгжүүлэх нөхцөлийг олгож байна.

зохицуулагч байгууллагуудад үнэт заасны зах зээлийн хяналтыг илүү үр дүнтэй хэрэгжүүлэх боломжийг олгож байна. Тус систем нь АНУ-д бүртгэлтэй бүхий л үнэт цаасны мэдээлэл болон АНУ-ын бирж, арилжааны системүүд дээрх мэдээллийг нэгтгэн өргөтгөсөн аудитыг гүйцэтгэхэд зориулагдсан. Амазон веб үүлэн технологийн хадгалах, тооцоолох, шинжилгээ гүйцэтгэх үйлчилгээг ашиглан нэгдсэн аудитын систем нь өдөр бүр 100 тэрбум гаруй зах зээлийн мэдээлэл, 22 хувьцааны бирж, 1500 брокер, дилерийн мэдээллийг ашиглан Үнэт цаас, биржийн хороо болон өөрийгөө зохицуулах байгууллагуудад зах зээлийн хяналтыг тооцоолох боломжийг олгодог ба олон нийтэд нээлттэй бүх төрлийн хувьцааны мэдээллийг нэг дор нэгтгэн, комплаенсын хяналтыг хэрэгжүүлэх боломжтой хамгийн анхны систем юм.

**Сингапур Улс:** Төв банк

**Төслийн нэр:** Project Mandala

**Технологи:** Big Data, RPA, Advance data collection, APIs, NLP

Банкны төлбөр тооцооны олон улсын хороо болон Сингапурын Төв банк хамтран Мандала төслийг хэрэгжүүлж буй бөгөөд гадаадын хөрөнгө оруулалт, гадаадын санхүүжилт босгох, гадаад төлбөр тооцоо зэрэг хил дамнасан үйл ажиллагааг зохицуулах, улс орнуудын хамтран баталсан эрх зүйн зохицуулалтын хэрэгжилтийг хангуулахад хяналт тавих зорилготой юм. Мандала төсөл нь комплаенсын хяналтыг хялбарчлах, бодит цагийн гүйлгээний хяналт хэрэгжүүлэх, улс хоорондын ил тод байдлыг хангуулах бөгөөд хяналтын үйл ажиллагааг автоматжуулснаар зохицуулалтын комплаенсын ачааллыг бууруулах, улс бүрийн дүрэм, журмын хэрэгжилтийг ил тод болгох боломжийг бүрдүүлсэн. Тус төслийг Банкны төлбөр тооцооны олон улсын хорооны инновацын хабын Сингапур дахь төв болон Австралийн Төв банк, Солонгосын Төв банк, Малайзын Төв банк, Сингапурын төв банк хамтран хэрэгжүүлж байна.

**Стресс төстийн хэрэгсэл:** суптекийн шийдлүүд нь санхүүгийн байгууллагууд стресстэй нөхцөлд хэрхэн ажиллаж буйг төрөл бүрийн эдийн засгийн нөхцөлүүдийг тавин үнэлэхэд ашиглагдаж байна. Энэ нь зохицуулагч байгууллагуудад эдийн засгийн хүндрэлтэй нөхцөл үүсэхэд зах зээлд үзүүлэх нөлөөг үнэлэн, зах зээлийн тасралтгүй үйл ажиллагааг хангуулахад чухал ач холбогдолтой.

**Эрт илрүүлэх систем:** машин сургалтын загварчлал болон бусад төрлийн ахисан түвшний алгоритмууд нь зах зээлийн өгөгдлийг тасралтгүй хянах, санхүүгийн тогтворгүй байдал болон системийн эрсдэлийг эрт илрүүлэх, зохицуулагч байгууллагууд урьдчилсан арга хэмжээг хэрэгжүүлэх боломжийг олгож байна.

### Суптек ашиглагдаж буй жишээ

**Хонг Конг Улс:** Үнэт цаас, фьючерсийн хороо

**Төслийн нэр:** Centralized Data Platform

**Технологи:** Rellational DBs, Big Data, Web Portals

Хонг Конгийн Үнэт цаас фьючерсийн хороо нь хяналт, шалгалтын үйл ажиллагаандаа технологийг тодорхой түвшинд ашиглаж ирсэн ч сүүлийн жилүүдэд илүү урагшлах алхам хийн төвлөрсөн өгөгдлийн платформыг хөгжүүлж байна. Технологийн тусламжтайгаар Үнэт цаас, фьючерсийн хороо нь илрээгүй зөрчил, зохицуулалтын орчны үл нийцэл, хяналт, шалгалтын үйл ажиллагаагаар илрүүлж чадаагүй зөрчлийг илрүүлж чаддаг хэдий ч олон төрлийн системээс өгөгдөл цуглуулах, нэгтгэх, цэвэрлэж, баталгаажуулах зэрэгт их цаг хугацаа зарцуулж ирсэн. Иймд уг үйл явцыг хялбарчлахын тулд салбарын оролцогчдын нийлүүлдэг арилжааны тоон мэдээллийг ижил хэлбэрт оруулах стандартыг салбарын оролцогчид болон зөвлөхүүдтэй хамтран боловсруулсан бөгөөд энэ нь салбарын оролцогчид Үнэт цаас, фьючерсийн хорооны веб рүү мэдээлэл нийлүүлэх, тус вебээс хяналт, шалгалтын шинжилгээг боловсруулах үйл явцыг хялбарчилсан. Үнэт цаас, фьючерсийн хороо нь зохицуулалтын нийцэл, зах зээлийн хяналт, тайлагналын зорилгоор ашиглах боломжтой их хэмжээний өгөгдлийн шинжилгээг гүйцэтгэх боломжтой дата лабыг үүсгэн байгуулсан.

**Ирланд:** Төв банк

**Төслийн нэр:** Social Media Monitoring for Market Conduct Supervision

**Технологи:** Advanced Data Collection, NLP, APIs

Олон нийтийн сүлжээг хянан шалгагчид эрт илрүүлэх системд ашиглах боломжтой. Тухайлбал Ирланд Улсын төв банк нь олон нийтийн сүлжээгээр дамжуулан санхүүгийн системд тусгай зөвшөөрөлгүй үйл ажиллагаа явуулж буй хэрэглээний зээлийн компанийг илрүүлсэн бөгөөд тус компани нь нэг удаагийн цахим шуудан, хуурамч нэр, хаяг ашиглан үйл ажиллагаа явуулж буйг тогтоосон. Ирландын Төв банк нь энэ төрлийн системийг ашиглан зохицуулалтгүй үйл ажиллагааг таних, олон нийтэд анхааруулга өгөх, зөвшөөрөлгүй үйл ажиллагаа явуулж буй компаниудыг зарлах байдлаар хэрэглэгчийг хамгаалах үйл ажиллагаагаа хэрэгжүүлдэг.

**Индонез:** Санхүүгийн үйлчилгээний газар

**Төслийн нэр:** Consumer support technology (CST)

**Технологи:** NLP, Big data, ML, Advanced Data Collection

Chatbot–CST хэлбэрийн хэрэглэгчид туслах технологи (CST) нь зах зээлийн үйл ажиллагааг бэхжүүлэхийн тулд их өгөгдлийн аналитик, машин сургалт, текст олборлолт болон бусад ижил төстэй технологийг ашиглан санхүүгийн хэрэглэгчдэд хяналт тавих, хэрэглэгчийн эрхийг хамгаалах зарчмыг зөрчиж болзошгүй санхүүгийн үйлчилгээ үзүүлэгчдийн гомдлыг шийдвэрлэн, зан төлөвийг тодорхойлон ажиллаж байна.

**Австрали:** Австралийн зохистой зохицуулалтын хороо

**Төслийн нэр:** APRA Connect

**Технологи:** BI, Big Data, APIs, Data validation

APRA Connect нь зохицуулалтын байгууллагуудын өгөгдөл, мэдээллийг Австралийн зохистой зохицуулалтын хороонд тайлагнах өгөгдөл цуглуулах шийдэл бөгөөд 2021 онд нэвтэрсэн. Австралийн зохистой зохицуулалтын хороо нь 2001 оны Санхүүгийн салбарын хуулийн дагуу өгөгдлөө цуглуулан зохистой хяналт, статистикийн нийтлэл болон түнш байгууллагуудтай хуваалцах зэргээр ашигладаг. APRA Connect нь ирээдүйд илүү өргөн хүрээний, илүү нарийвчилсан тоон мэдээллийг цуглуулах боломжийг бүрдүүлж буй бөгөөд энэ нь хяналт, зохицуулалтын үйл ажиллагаа болон хамтын ажиллагаатай байгууллагуудын өгөгдөл, мэдээллийн шаардлагад илүү нийцтэй болох юм. Энэхүү систем нь тоон мэдээллийг бага нэгтгэн, салбарын үндсэн мэдээллийн бүтцэд илүү нийцүүлэхээр бүтээгдсэн бөгөөд 2022 онд Австралийн засгийн газрын цахим үнэмлэхийн системтэй холбогдсон. Тус цахим үнэмлэхийн систем нь Австралийн иргэд, аж ахуй нэгжүүдэд төрийн болон бусад төрлийн үйлчилгээг цахимаар нэг дороос найдвартай авах боломжийг олгодог.



САНХҮҮГИЙН  
ЗОХИЦУУЛАХ  
ХОРОО

Монгол Улсын санхүүгийн хүртээмжийг сайжруулах хөтөлбөрийн хүрээнд

## Цуврал №40

### Жолоочийн хариуцлагын албан журмын даатгал гэж юу вэ?



Жолоочийн хариуцлагын албан журмын даатгал нь зам тээврийн ослын улмаас бусдын **амь нас, эрүүл мэнд, эд хөрөнгөд** учруулсан хохирлыг даатгалын компани даатгуулагчийн өмнөөс бусдад учруулсан хохирлыг барагдуулна.



Даатгалын гэрээ **1 жил** хүртэл хугацаанд хүчинтэй байх бөгөөд даатгалын компанийг сайн дураараа сонгох эрхтэй.

#### Даатгуулагч гэж :

- Тээврийн хэрэгслийн өмчлөгч бүр
- C, D ангиллын жолооч

Монгол Улсын нутаг дэвсгэрт түр саатах гадаадын тээврийн хэрэгслийн жолооч



#### Даатгалын хураамжийг хэрхэн тооцдог вэ?

- Тээврийн хэрэгслийг ашиглах жолоочийн тоо
- Тээврийн хэрэгслийн зориулалт
- Даатгуулагчийн нас туршлага
- Газар нутгийн байршил
- Гэрээний хугацаа
- Чиргүүлтэй эсэх



ЗАХ ЗЭЭЛИЙН СУДАЛГАА, ХӨГЖЛИЙН ГАЗАР



САНХҮҮГИЙН  
ЗОХИЦУУЛАХ  
ХОРОО

Монгол Улсын санхүүгийн хүртээмжийг сайжруулах хөтөлбөрийн хүрээнд

## Цуврал №40

### Жолоочийн хариуцлагын албан журмын даатгалд даатгуулагч ямар үүрэг хүлээх вэ?



Даатгалын хураамжийг хууль болон гэрээнд заасан хэмжээгээр бүрэн төлөх;



Даатгал хийлгэхтэй холбоотой баримт материалыг үнэн зөв гаргаж өгөх;



Даатгалд даатгуулсан тухайгаа хохирогчид мэдэгдэх;



Даатгалын тохиолдол гарсан талаар даатгагч, цагдаагийн байгууллагад нэн даруй мэдэгдэх;



Хохирлыг нөхөн төлөхөөр жолооч хохирогчтой тохиролцсон бол энэ тухайгаа даатгагчид мэдэгдэх;

#### Даатгуулагчийн анхаарах зүйлс :

- Даатгалын гэрээг стандарт загварын дагуу бичгээр, эсхүл цахим хэлбэрээр байгуулна.
- Жолооч нь даатгалын баталгааг автотээврийн хэрэгсэлд байнга байршуулна.
- Ослын шалтгааныг нотлох мэргэжлийн байгууллагад заавал мэдэгдэж акт, дүгнэлт авах;
- Осол болсон орчим нөхцөлийг харуулан зураг авч баталгаажуулах;



“ЖОЛООЧИЙН ХАРИУЦЛАГЫН АЛБАН ЖУРМЫН ДААТГАЛЫН ТУХАЙ” хуулийг дараах QR кодыг уншуулан танилцана уу.

ЗАХ ЗЭЭЛИЙН СУДАЛГАА, ХӨГЖЛИЙН ГАЗАР

## ОЛОН УЛСЫН ЗАХ ЗЭЭЛИЙН МЭДЭЭ

**ХОЛБООНЫ НӨӨЦИЙН САНГИЙН (ХНС) МӨНГӨНИЙ БОДЛОГЫН ШИЙДВЭР ГАРАХААС ӨМНӨ АЛТ ШИНЭ ДЭЭД ЦЭГТЭЭ ХҮРЛЭЭ – ШИНЖЭЭЧИД ИРЭХ ЖИЛ ГЭХЭД УНЦ 3000 АМ.ДОЛЛАР БОЛНО ГЭЖ ҮЗЭЖ БАЙНА.**



(8 дугаар сарын 19) Алтны ханш шинэ дээд цэгтээ хүрч, шинжээчдийн үзэж байгаагаар илүү их дээд амжилт тогтоох төлөвтэй байна. ХНС-ийн хурал ойртож байгаа энэ үед алтны ханш унц нь ирэх жил 3,000 ам.долларт хүрнэ гэж таамаглаж байна.

FactSet-ийн мэдээлснээр спот алтны ханш унц нь 2,508.14 ам.долларт хүрсэн бол АНУ-ын алтны фьючерс 0.16 хувиар өсөж, даваа гарагт 2,540.8 ам.долларт хүрч шинэ дээд амжилт тогтоон өсөлтөө үргэлжлүүлэв.

ХНС-гийн мөнгөний бодлогын шийдвэрээс хамааран ирэх сард алтны ханш унц нь 2,700 ам.долларт хүрэх магадлалтай” гэж Business monitor international (BMI)-ийн шинжээч хэлэв. Мөн “2024

он бол алтны ханш хэд хэдэн дээд цэгт хүрэх жил” гэж BMI-ийн түүхий эдийн шинжилгээний албаны дарга Сабрин Чоудхури дурджээ.

Зээлийн хүү буурч байгаа нь ам.долларын ханшийг дарамталж, ногооноор үнэлэгдсэн гулдмай бусад валют эзэмшигчдийн сонирхлыг татаж байна.

“Citi” банкны шинжээчдийн таамаглалаар дөрөвдүгээр улиралд алтны ханш унц нь 2,550 ам.доллар, 2025 оны дунд үе гэхэд унц нь 3,000 ам.доллар болно гэж таамаглаж байна.3,000 ам.доллар байна гэж таамаглаж байна.

Эх сурвалж: [www.cnbc.com](http://www.cnbc.com)

### ОЙРХ ДОРНОДЫН МӨРГӨЛДӨӨН ХУРЦДАЖ, ЛИВИЙН ОЛБОРЛОЛТ ЗОГССОНЫ УЛМААС ГАЗРЫН ТОСНЫ ҮНЭ 3 ХУВИАР ӨСЛӨӨ.

Ойрх Дорнодод хурцадмал байдал үүсээд байгаатай холбоотойгоор Ливийн газрын тосны олборлолт зогсонги байдалд орж, газрын тосны үнэ өссөн байна.


West Texas Intermediate төрлийн газрын тосны үнэ 3 хувиас дээш өсөж баррель нь 77.42 доллар болсон бол олон улсын жишиг үнэ Brent төрлийн газрын тосны үнэ 3 хувиар өсөж, баррель нь 81.43 долларт хүрч хаагдсан.

Ливийн зүүн бүсийн засгийн газар Ливийн төв банкны удирдлагуудын маргаантай холбогдуулан үйлдвэрлэл, экспортоо түр зогсооно гэж мэдэгдсэний дараа газрын тосны үнэ өссөн. Мөн ирэх сард АНУ-ын Төв банк бодлогын хүүгээ бууруулах хүлээлт газрын тосны үнэд голлон нөлөөлсөн байна.

Олон улсын эрчим хүчний агентлагийн мэдээлснээр, өнгөрсөн сард Ливи улс өдөрт 1 сая гаруй баррель түүхий газрын тос олборложээ.



Эх сурвалж: [www.finance.yahoo.com](http://www.finance.yahoo.com)



## ХЯТАД, БЕЛАРУСЬ ХУДАЛДАА, АЮУЛГҮЙ БАЙДЛЫН САЛБАРТ ХАМТЫН АЖИЛЛАГААГАА БЭХЖҮҮЛЭХЭЭР ТОХИРОЛЦОВ.

БЭЭЖИН, 8 дугаар сарын 23 (Ройтерс) – БНХАУ–ын Төрийн зөвлөлийн Ерөнхий сайд Ли Цян Беларусийн Ерөнхий сайд Роман Головченкотой Минск хотноо уулзаж Хятад, Беларусь худалдаа, аюулгүй байдал, эрчим хүч, санхүү зэрэг олон салбарт хамтын ажиллагаагаа бэхжүүлэхээр тохиролцсон тухай хамтарсан мэдэгдэлд дурджээ.

Минскийн уулзалтаас нэг өдрийн дараа буюу баасан гарагт гаргасан мэдэгдэлд хоёр улс аж үйлдвэрийн хангамжийн сүлжээн дэх хамтын ажиллагаагаа бэхжүүлж, хоёр талын

зардлаа бууруулахын тулд худалдааг хөнгөвчлөх ажлыг үргэлжлүүлнэ гэжээ.

Түүнчлэн Беларусь улс Гуандун, Хонконг–Макаогийн Гуанжоу, Шэньжэн, Жухай зэрэг есөн хотыг хамарсан мегаполистой хамтын ажиллагаагаа гүнзгийрүүлэх бодолтой байна гэж Хятадын гадаад харилцааны яамны нийтэлсэн мэдэгдэлд дурджээ.

Хятадын "Бүс ба зам" санаачилгыг хүлээн авсан анхны бүлгийн нэг бол Беларусь улс байсан бөгөөд Ли Минск хотод айлчлах үеэрээ олон улсын байдал өөрчлөгдсөн хэдий ч сүүлийн 32 жилийн турш Хятад, Беларусийн харилцаа идэвхтэй хэвээр байна гэж "China Daily" сонинд бичжээ.

Тус сонинд мөн Хятад улс бол Беларусийн хоёр дахь Ази дахь хамгийн том худалдааны түнш бөгөөд өнгөрсөн онд хоёр талын худалдаа 8.4 тэрбум ам.доллар давсан гэж тэмдэглэжээ.

Эх сурвалж: [www.reuters.com](http://www.reuters.com)

## 2024 ОНЫ 8 ДУГААР САРЫН 28–НД NVIDIA КОМПАНИЙН ОРЛОГЫН ТАЙЛАН ГАРНА.

Лхагва гарагт Nvidia компанийн орлогын тайлан гарах бөгөөд хөрөнгө оруулагчид хүлээж байгаатай холбоотойгоор АНУ–д нэг шөнийн дотор гурван гол индекс бүгд өсжээ. Dow Jones 0.02 хувиар өсөж, 41,250.5–д хүрч дахин нэг дээд амжилт тогтоов.

S & P 500 болон Nasdaq индекс 0.2 хувиар өсөж 17,754.82 нэгжид хүрсэн.

Эх сурвалж: [www.cnbc.com](http://www.cnbc.com)



# ОЛОН УЛСЫН ХӨРӨНГИЙН ЗАХ ЗЭЭЛИЙН ИНДЕКС

2024 оны 08 дугаар сарын 23-ны өдөр



Засгийн газрын IV байр, Бага тойруу-3, Чингэлтэй дүүрэг,  
Улаанбаатар хот, Монгол Улс 15160



976-51-264444



press@frc.mn



www.frc.mn



Санхүүгийн зохицуулах хороо



@FRC\_of\_Mongolia

